

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY


2014 ОНЫ 10 САР. №17 (075)

ЭДИЙН ЗАСАГ  
ИНФЛЯЦИЙГ УДИРДАХ БОЛОМЖ


ДЭД БҮТЭЦ  
ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР

БИЗНЕС  
МАНЛАЙЛАГЧИЙН ДҮР ТӨРХ

WWW.MONGOLIANECONOMY.MN



**ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙНХЭН  
ХООЛОНДОО!!!**





Чухал цаг үеэ тасралтгүй үргэлжлүүл

HOME NETWORK BATTERY BACKUP

Тог тасарсан ч гэсэн таны гэрийн Wifi сүлжээг тасралтгүй ажиллуулах шинэ төрлийн Back-UPS тог баригчийг танилцуулж байна.

Life Is On™

**APC**<sup>™</sup>  
by Schneider Electric

*PC mall*



Миний амьдрал дахин давтагдашгүй гайхамшигт загваруудыг бүтээх хүсэл эрмэлзлэл, тэмүүлэл дунд үргэлжилдэг

# Миний карт American Express

Эрхэм та өндөр дүнтэй зээлийн эрх болон нууцлал хамгаалалт бүхий American Express Gold Card эзэмшигч болсноор олон улс болон дотоодын нэр хүнд бүхий үйлчилгээний байгууллагууд, нисэх буудлуудын вип танхимуудаар үйлчлүүлэн иж бүрэн даатгалтайгаар аялж, ажиллах боломжтой болохоос гадна гүйлгээ хийн оноо цуглуулж онцгой хөнгөлөлт урамшуулуудыг авах болно.



Дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.americanexpress.mn](http://www.americanexpress.mn)-ээс

 **ГОЛОМТ БАНК**  
Сайн сайхныг санхүүжүүлнэ



Миний амьдрал. Миний карт.

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

## АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

## ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

## ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

## СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

## ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

## МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав / 9409-2904

## “MONGOLIAN ECONOMY”

### СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

#### Б.БЯМБАСАЙХАН

Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, "Mongolian Economy" сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

#### Б.БОЛД

"Рио Тинто" компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

#### С.БЭХБАТ

ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

#### Д.ЖАРГАЛСАЙХАН

МНН группын ерөнхийлөгч

#### Ц.БАТСҮХ

СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

#### Ж.СҮНЖИДМАА

"Пийбоди Энержи" компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

#### Б.ТҮВШИНТӨГС

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

## ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 504 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

## ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Mongolian Economy сэтгүүлийн ээлжит шинэхэн дугаарыг хүлээн авч байгаа эрхэм уншигч, захиалагч та бүхний энэ өдрийг амрыг эрин мэндчилж байна.

Намар оройн жиндүү салхинд шилбүүрдүүлсэн монголчууд түлээ түлш, дулаан хувцасаа базааж, хөдөөний малчид өвс хадлангаа татаж, өвөлжөө бууцандаа төвхнөхөөс авахуулаад тун завгүй. Харин улс төрийн амьдрал юун өвөл хаалга тогшин буйг мэдэхтэй манатай сонирхолтой бас бужигнаантай. Шинэчлэлийн Засгийн газар

бүтцийн өөрчлөлт хийж, БНСУ-д удал эмчилгээ хийлгэсэн Монгол Улсын төрийн гурван өндөрлөгийн сэнтийд заларч асан МАХН-ын дарга Н.Энхбаяр эх орондоо ирсэн нь хөдөлгөөн ихтэй байгаа улс төрийн амьдралыг улам сонирхол, таавраар дүүргэсэн гээд олон содон үйл явдал өрнөсөн хагас сар өнгөрч байна.

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж, Ерөнхий сайдыг огцруулна, огцруулахгүй тухай маргаж буй улс төрийн халуун тогооны ууранд ужигран даамжирсан эдийн засгийн хүндрэлтэй холбоотой яриа хөөрөө нам дарагдав бололтой.

Н.Алтанхуягийн шимтэн, шаналан байж боловсруулсан Засгийн газрын шинэ бүтэц өмнөхөөс дээр байна гэж итгэхэд бэрхтэйг олон нийтийн хандлага харуулах ажгуу. Энэ тухай мэдээллийг манай сэтгүүлээс аваарай.

Улс төрийн томилгоо хэрүүлтэй уруултай болоод өнгөрөх л байх. Хамгийн чухал нь Намрын чуулганаар ирэх оны Төсөв, Мөнгөний бодлого зэрэг нийгэм эдийн засгийн чухал бодлогын баримт бичгүүдийн төслийг өргөн барьж, хэлэлцүүлэх учиртай. Гэтэл Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор Төсвийн төслийг эргэн татаад буй нь тун таагүй зүйл юм. Улс төрийн толхилцоонтой битгий хэл, жирийн үед Төсвийг хуулиар товлосон хугацаанд нь амжиж батлах гэж бөөн юм болдог доо. Одоогоор бэлэн болсон Төсвийн төслийг Засгийн газрын шинэ бүтэц хэрхэн бужигнуулахыг бүү мэд. Ямартай ч манайх ном болгон хэлэлцүүлэгт бэлтгэсэн ирэх оны төсвийн төслийн гол тоон мэдээллийг шинжин үзэж, дүр төрхийг нь танадлаа.

Мөн саяхан Дэлхийн банк, АХБ-ны бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн таамгийг шинэчилсэн ээлжит тайлангууд гарав. Монгол Улсын өсөлтийн талаарх тоон таамгийн тоймоор дугаарынхаа англи талын эхний нүүрийг "чимлээ". Өсөлтийн шинэхэн тоонуудтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох материалуудаас сонирхоно биз ээ.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ



facebook.com/MongolianEconomy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy



## МОНГОЛД

### Ногоон эдийн засаг



НҮБ-ын Статистикийн хэлтсээс “Ногоон эдийн засагт шилжих явцыг үнэлэх нь” төслийг эхлүүлж, Ази, Номхон далайн бүсээс хамрагдах дөрвөн орны нэгээр Монгол улс сонгогдсон. Энэ хүрээнд Үндэсний статистикийн хорооноос ногоон ажлын байрны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг явуулсан байна. Судалгаанд хамруулсан 569.9 мянган ажлын байрны 11.5 хувь нь л ногоон ажлын байр гэсэн тодорхойлолтод тэнцсэн байна. Энэ нь Монгол Улс дахь нийт хөдөлмөр эрхлэлтийн 6.2 хувийг эзэлж байгаа аж.

### Авлига

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, авлигатай тэмцэх газрын хамтран зохион байгуулж буй “Нээлттэй Улаанбаатар-2014” авлигын эсрэг олон улсын форум энэ сарын 6,7-нд боллоо. Форумд 18 улсын 250 гаруй төлөөлөгч хэлэлцсэний үндсэн дээр “Авлигын эсрэг Улаанбаатарын тунхаглал”-ыг гаргасан байна. Дэлхийн банкны судалгаагаар, 2012 оны нийслэлийн төсвийг 35 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний орлогыг авлигад зарцуулжээ. Харин тус тунхаглалыг гаргаснаар Улаанбаатар хот бүс нутагтаа төдийгүй дэлхийд авлигагүй хот болох зорилгодоо хүрэхэд нэг алхам ойртлоо гэдгийг Нийслэлийн удирдлагууд онцолж буй.

### Хөрөнгө оруулалт

Намрын ээлжит чуулганаар “Олон Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээр” батлах хуулийн төслийг хэлэлцэхээр болсон юм. Энэ үеэр УИХ-ын дарга З.Энхболд “Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин сайжирсан бөгөөд хөрөнгө оруулагчдад илүү боломжуудыг бид олгож буй” гэдгийг онцолсон.

Түүнчлэн, Хойд Америк, Монголын бизнесийн



зөвлөлийн хөрөнгө оруулагчдын 17 дахь удаагийн зөвлөлөгөөнөөр манай улсад хоёр хөршийн хамтын ажиллагаа голлох байр суурь эзэлж байгаа ч Монгол Улс тогтвортой хөгжихийн тулд гуравдагч хөршийн холбоогоо бэхжүүлэх хэрэгтэй хэмээн хуралд оролцогчид санал нэгдлээ.

### 888 төсөл



Шинэчлэлийн Засгийн газраас нээлттэй зарласан экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох 888 төслийн хүрээнд 56 төсөл дэмжигдээд байгаа аж. Хөгжлийн банкны мэдээлж байгаагаар төслүүдэд

санхүүжилт олгож эхэлсэн байна. Салбарын хувьд хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөл 20, хувцас хөнгөн үйлдвэрийн 18, барилгын материал үйлдвэрлэлийн 16, эм үйлдвэрлэлийн хоёр төсөл санхүүжилтээ авч эхэлжээ.


### Эдийн засаг

Дэлхийн банк Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн тайлангаа шинэчлэн гаргасан. Тус тайланд Монголын эдийн засгийн өсөлтийн төлөвийг 3.2 хувиар бууруулж, 6.3 хувь болгосон байна. Энэ оны дөрөвдүгээр сард гаргасан тайланд Дэлхийн банкны мэргэжилтнүүд манай улсын эдийн засгийг энэ жил 9.5 хувиар өснө гэж тооцоолж байсан билээ. Харин ирэх оны хувьд Монголын эдийн засгийг ердөө 6.2 хувь, 2016 онд 6.6 хувь өснө гэж үзжээ. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны энэ сард гаргасан тайлангаар бүс нутгийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн төлөв өнгөрсөн онд 6.1 хувь байсан бол энэ онд 6.2 хувьтай гарчээ. Харин ирэх онд 6.4 хувьд хүрэх төлөв ажиглагдаж буй аж. Энэ оны эхний хагасын өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 16.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

### ДЭЛХИЙН МЭДЭЭ

#### Орос, Хятад

Барууны орнууд ОХУ-ын эсрэг хориг тавиад буй энэ үед хоёр хөрш хоорондын гадаад худалдаагаа нэмэгдүүлэх талаар Москва хотноо хэлэлцэж байна. Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд хөршүүдийн гадаад худалдаа хоёр



дахин өссөн гэдгийг ОХУ-ын Ерөнхий сайд Дмитрий Медведев хэлсэн. Украины улс төрийн тогтворгүй байдал, Оросын тусгаарлагдсан байдлаас үүдэн тус улсын эдийн засгийн өсөлт хоёр хувь байх талаар Олон улсын валютын сан мэдээлжээ. Иймд ОХУ урт хугацааны уналтад орохгүйн тулд Хятад болон бусад зүүн бүсийн хөршүүддээ түшиглэх аж.

#### Казахстан


Каспын тэнгисийн хойд хэсэгт байрлах Кашаган газрын тосны орд дэлхийд тэргүүлдэг. Харамсалтай нь төлөвлөгөөт төсвийг 30 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэн 43 тэрбум ам.долларыг зарцуулаад буй энэ ордын олборлолт тасарсан, төлөвлөгөөт нийлүүлэлт өсөн жилээр хоцорж буй гэх таагүй мэдээ байна. Түүнчлэн Казахстаны Засгийн газар Тэнгиз газрын тосны ордод өргөтгөл хийх төслийг баталсан нь 40 тэрбум ам.долларын санхүүжилт шаардах аж. Дээрх ордуудыг тус улсын “KazMunayGas” төрийн өмчит компани эзэмшдэг бөгөөд “Exxon”, “Chevron”, “Lukoil”, “Shell” зэрэг гадаадын компаниудын консорциумынх аж. Байгаль орчныг хамгаалах журмыг зөрчсөн гэх үндэслэлээр Казахстаны Засгийн газар дээрх холбоонд хоёр тэрбум ам.долларын торгууль

ногдуулаад байгаа аж. Олон улсын байгууллага, шинжээчдийн үзэж буйгаар ийн торгуулийн арга хэмжээ авсан нь цаашид хөрөнгө оруулагчдыг үргээх нөхцөл болно хэмээн үзэж байгаа юм. Кашаган ордоос газрын тос олборлох ажлыг 2016 он хүртэл зогсоосон гэдгийг Казахстаны Засгийн газраас мэдэгдсэн.

### Монгол



-Мөргөлдөөн таслан зогсоох үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол Улс энхийг сахиулах цэрэг дайчдын тусламж үзүүлэхээ НҮБ-д мэдэгдлээ. НҮБ-аас гаргасан судалгаагаар Монгол Улс өнгөрсөн жил 937 энхийг сахиулах цэрэг гаднын орнуудад илгээсэн байна.



-“The Economist Intelligence Unit”-ээс гаргасан аравдугаар сарын таамгаар Монгол Улс инфляци өндөртэй орнуудын эхний аравт оржээ. Өнгөрсөн долдугаар сард 14.9 хувь хүрээд байсан инфляци 13 хувь болж буурсан үзүүлэлттэй байгааг Монголбанкнаас мэдээлсэн. Монголын инфляцийн түвшин Азид хамгийн өндөрт тооцогдож байна. ■



## # МОНГОЛ ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

**Улс төр Өмнөд Африк** @PoliticsZA 05/10 #Либер #Монгол улс хамгийн их өртсөн орнууд. Иргэдийнх нь 86 хувь нийтийн салбар дахь авлига хэрээс хэтэрсэн гэж үзжээ.

**Хэрэв Монгол Улс Засгийн газар авлигын “соёл”-оосоо салах хүсэлтэй байгаа бол хойч үедээ итгэл хүлээлгэх ажилд ханцуй шамлан орох хэрэгтэй.**

**IRI** @IRIglobal 07/10 #ИлтөдУлаанбаатар2014 форумын талаар сонирхолтой @Asia\_Foundation нийтлэл <http://bit.ly/1skPdjl> #Монгол

**Авлигын эсрэг Ил тод Улаанбаатар 2014 сэдэвт хурлын үеэр:** “Монголд авлига нийгмийн нэг хэсэг, тогтсон хэв маяг болжээ. Ингэснээр төр иргэдийнхээ хүсэл сонирхлын эсрэг үйл ажиллагаа явуулж эхэлдэг. Төр иргэдийнхээ дайсан болж хувирдаг. Энэ нь ардчиллын гол зарчмуудыг үгүй хийж байгаа юм” - Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн засаг дарга Э.Бат-Үүл

“Ардчиллыг бэхжүүлэх, авлигын сөрөг үр дагаварыг таниулахад Ил тод Улаанбаатар 2014 сэдэвт хурал тодорхой үүрэг гүйцэтгэнэ” - IRI-ийн захирал Марк Грийн

**Жулиан Дийркес** @jdierkes 07/10 **К Прийсли** (@TurquoiseHillRe) Канадын хамгийн өндөр цалинтай 100 захирлын жагсаалтанд (өнгөрсөн жил 1.8 ам.долларын орлогоор) багтжээ. (Хамгийн өндөр орлоготой дөрөв дэх эмэгтэй.) <http://fw.to/A02NeyT> #Монгол

**Канадын уул уурхайн “Turquoise Hill Resources” компани, өмнө нь “Ivanhoe Mines”, Оюу Толгой төслийн толгой байгууллага юм.**

**The EIU** @TheEUI 30/09 #Монгол Улсын өсөлт 2015 онд найман хувь байх нь. Энэ нь уул уурхайн хөрөнгө оруулалт, экспорт нэмэгдэхтэй холбоотой аж. <http://bit.ly/1oQcDeB>

**2014 оны сүүл, 2015 оны эхээр Монгол Улс эдийн засгийн хямралд өртөх магадлалтай байна. “Economic Intelligence Unit” Монголын ДНБ ирэх онд найман хувиар өснө хэмээн таамагласан ч энэ нь хямралын дараах зураглал гэнэ.**

**Монгол Эр** @BaatarEnkhbat 12/10 @Battumurl: Цөөхөн юм зардаг бол наймаачин, их бараа зардаг бол бизнесмэн, улсаа зардаг бол улс төрч #гэнээ

Өнгөрсөн дөрөвдүгээр сард Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүний хөгжлийн газар, Иргэний боловсролын төв хамтран явуулсан “Монголын залуучууд, Ардчилал улс төрийн оролцооны талаарх ойлголт төсөөлөл” сэдэвт судалгаанд 1248 залууг хамруулсан. Судалгааны дүгнэлтэд залуусын дийлэнх нь төр засгийн удирдлагуудад итгэх итгэл буурсан. Тэдний “эрх ашгийг хөндсөн асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд нөлөө үзүүлэх боломж багатай байгаа” гэжээ.

**АлагШагай** @alagshagai 06/10 Би уг нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэж их үзэх юм. Гутал захиаллаа томдуулсан, цүнх захиаллаа бас шал өөр юм хийж. Ямар ч урамгүй

“Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе” төслийн I, II шат амжилттай хэрэгжиж дууссан гэх. Төслийн өмнөх шатад хамрагдсан бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадваржуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулах, Монголын брэнд бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд шинээр гаргах зорилгын дор II шат өндөрлөжээ. Дотоод зах зээлийн сэтгэл ханамж, хангамж сайжраагүй байхад гадаад зах зээл рүү тэмүүлэх нь зөв үү?



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

Монгол Улс ирэх онд 20 сая тонн нүүрс экспортолно

## ТӨСӨВ

# ИРЭХ ОНЫ ТӨСВИЙН ТӨРХ

### Б.БАЯРТГОТХ

Засгийн газрын шинэ бүтэц тодорхой болохын зэрэгцээ энэ оны төсөвт тодотгол хийх шаардлагатай байгаа. Үүний дараа 2015 оны төсвийн төслийг УИХ авч хэлэлцэхээр болсон. Засгийн газар УИХ-д өргөн барьсан төсвийн төслөө эргүүлэн татсан. Гэхдээ ирэх оны төсвийн төсөлд эрс өөрчлөлт гарахгүй гэж Сангийн сайд Ч.Улаан мэдэгдсэн. Ингээд үзэхээр төсвийн төрх нэг их эвдэгдэхгүй нь. Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө энэ оны эхний найман сарын байдлаар 623.8 тэрбум төгрөгөөр тасарсан. Он дуустал нэмж 130 тэрбум орчим төгрөгөөр тасрах эрсдэлтэй байна. Энэ оны хувьд нийтдээ 750 тэрбум төгрөгөөр төсвийн орлого дутах бололтой. Орлого төвлөрөхгүй гэдэг нь зарлага гарахгүй гэсэн үг.

Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн

засагч Тэхюн Ли “Төсвийн алдагдал өндөр гарахаар байна. Монголчууд бүсээ чангалж, үргүй зардлыг бууруулах шаардлагатай” хэмээн сануулсан. Сангийн яамнаас УИХ-ын хэлэлцүүлэгт зориулж бэлтгэсэн “Ирэх оны төсвийн төсөл” гэх зузаан ном гишүүдийн гарт очоод буй. Түүнийг сонирхвоос ирэх онд валютын ханшийг 1750 төгрөгөөр тооцжээ. Одоогийн байдлаар ам.доллар 1850 орчим төгрөгтэй тэнцээд буй.

2015 оны төсвийн алдагдал ДНБ-ий зургаан хувьд хүрэхээр байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийг зөрчиж байгаа юм. Хуульд зааснаар төсвийн алдагдал ДНБ-ий хоёр хувиас хэтрэх учиргүй. Алдагдал өндөр гарах болсон шалтгаан нь төсвөөс гадуурх зардлыг ирэх оны төсөвт нэмж суулгасантай холбоотой аж. Ингэснээр Монгол Улсын төсөв нэг дээвэртэй болж буйг

Сангийн сайд Ч.Улаан онцолсон. Төсөвт бүтцийн өөрчлөлт хийж, нэмэлт зардлыг тооцооноор алдагдал гурав дахин өсөх нь.

Төрийн захиргааны зардлыг нэмэхгүй байх зарчмыг энэ удаагийн төсөвт баримталжээ. Ингэснээр төсөв хэмнэлтийн горимд шилжиж, тодорхой зарлагуудад хязгаарлалт хийж. Тухайлбал, удирдлагын зардлыг одоогийнхоос нэмэхгүй аж. Мөн орон тооны болон шат дамжлагын зардлыг тэлэхгүй байхаар төсвийн төсөлд тусгаж өгчээ. Сангийн сайдын хэлж буйгаар 2015 он Монгол Улсын хувьд зардлыг “тэвчих” жил. Гэхдээ ямар ч хөрөнгө оруулалт огт хийгдэхгүй нь гэж ойлгож болохгүй. Онцын үр өгөөж өгөхгүй, зарлага дагуулах зардлыг “тэвчих” юм байна. Мөн энэ оны төсөвт суугаагүй 420 тэрбум төгрөгийн “царцаасан” барилгууд ирэх оны төсөвт ч багтаагүй аж. Ингээд үзэхээр ▶

► ирэх онд төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэг, эмнэлэг шинээр баригдахгүй нь.

Харин нийгмийн шинж чанартай зарим хөрөнгө оруулалтыг нэмэхээр болсныг дуулгая. Жишээлбэл, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэхэд зориулж 500 тэрбум төгрөг төсөвт суулгасан байна. УИХ дахь МАН-ын бүлгийн

**Нүүрсний хувьд 20 сая тонн нүүрс экспортолно. Нэг тонн нүүрсийг 80-130 ам.доллараар арилжаална гэсэн өөдрөг төсөөллийг Сангийн яамныхан хийсэн байна. Энэ оны хувьд манайх 31.4 сая тонн нүүрс экспортолно гэж төсөвт хуульчилсан.**

дэд дарга Д.Оюунхорол “Засгийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор Засгийн газар төсвийн төслөө эргүүлэн татаж дахин өргөн барих ёстой. Одоогийн төсөлдөө тусгасан мөнгө нь төрийн албан хаагчдын цалин, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг 2.5 дахин нэмэгдүүлэхэд хүрэлцэхгүй” гэв. Харин Сангийн сайд үүнийг “Хангалттай” хэмээсэн.

Төсвийн алдагдал эхний жилдээ өндөр гарч байгаа бөгөөд цаашдаа шат дараалан буулгаж 3-4 жилийн дотор хоёр хувийн түвшинд ойртуулах зорилт дэвшүүлж. Ирэх оны төсвийн удаах онцлог нь Орон нутаг, анхан шатанд төсвийн эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг цогцоор шилжүүлсэн явдал. Хэмнэлтийн горимд шилжээд буй ирэх оны төсөвт 7.2 их наяд төгрөгийн орлого төвлөрч, 8.4 их наядын зарлага гарна. Үүнд “Чингис” бонд болон Хөгжлийн банкны эх үүсвэр багтсан.

Төсвөөс нийтдээ ирэх жил хөгжлийн хөрөнгө оруулалтад 828 тэрбум төгрөг зарцуулах аж. Төсвийн

төсөл нь бодлогын баримт бичиг. Хязгаарлагдмал санхүүгийн нөхцөлд нийгмийн хэрэгцээ шаардлагыг гүйцэлдүүлэх амаргүй зорилтыг өмнөө тавьдаг. Ирэх онд уул уурхайн салбар нэгдсэн төсвийн нийт орлогын 1.7 их наяд төгрөгийг бүрдүүлэх юм.

Нүүрсний хувьд 20 сая тонн нүүрс экспортолно. Нэг тонн нүүрсийг 80-130 ам.доллараар арилжаална гэсэн өөдрөг төсөөллийг Сангийн яамныхан хийсэн байна. Энэ оны хувьд манайх 31.4 сая тонн нүүрс экспортолно гэж төсөвт хуульчилсан. Гэвч амьдрал дээр 12.2 сая тонн нүүрс өмнөд хөршдөө нийлүүлжээ. Хятадын далайн эргийн боомтуудад нэг тонн угаасан нүүрс 120 ам.долланы үнэтэй байгаа. Манай улсын хувьд түүхий нүүрсээ нэг тонныг нь 35 ам.доллараар борлуулж байна.

Төсвийн орлогын тухайд энэ оныхоос 900 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол зарлага нэг их наяд төгрөгөөр тэлсэн. Төсвийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор ирэх онд төсвийн орлого, зарлага нэлээд хэмжээгээр өөрчлөгдсөн. Гарааны жилдээ орлого, зарлагын үзүүлэлт ч өндөр байх нь. Тиймээс Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөн ч хэмнэлт маш бага хийгдэх аж. Бүтцийн өөрчлөлт хийсэн

эхний жилд тооцож байсан нийт хэмнэлтийн багахан хувь нь гардаг байна.

Төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх онд ДНБ-ий өсөлтийг 7.1 хувиар тооцжээ. Улсын төсвөөс хуваарилах хөрөнгө оруулалт буурсан ч бондоос хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээнд хийгдээд явах нь ээ. Монголбанкны зүгээс энэ оны өсөлтийг 3.6 хувиар төсөөлсөн бөгөөд ирэх оныг 6.1 хувийн өсөлттэй байна гэсэн. Чингис бонд, Хөгжлийн банкны эх үүсвэр, хөнгөлөлттэй зээл нэмэгдэж байгаа. Энэ утгаар нь авч үзвэл хөрөнгө оруулалт нийт дүнгээр өснө гэж Сангийн сайд мэдэгдсэн удаатай.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан байдаг. Харин улсын өрийн хязгаарыг нэмэгдүүлэхийн тулд төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дээрх заалтыг нэн түрүүнд шинэчлэх тухай хуулийн төслөө УИХ-д Засгийн газар өргөн барьсан. Нэг талаар бондын эх үүсвэрийг төсөвт нэгтгэсэн нь хуульд өөрчлөлт оруулахад хүргэж буй. Өөрөөр хэлбэл, УИХ баталсан хуулиа үгүйсгэж байгаа нь ирэх оны төсвийг хэлэлцэх үеэр тод харагдах бололтой. ■

## МӨНГӨНИЙ БОДЛОГО

# ИНФЛЯЦИЙГ УДИРДАХ БОЛОМЖ

### Б.БАЯР

Монголбанк инфляцийн зорилтот шинэ түвшингээ тодорхойлжээ. Тэд хяналтаас аажмаар гарч буй инфляцийн эсрэг мөнгөний бодлогоо чангатгах нь. Ингэснээр улсын хэмжээнд 13 хувьд хүрээд буй инфляцийг ирэх оны эцэст долоон хувиас хэтрүүлэхгүй гэв. Өнгөрсөн жил энэ оны инфляцийн түвшинг найман

хувиас доошгүй байхаар Н.Золжаргал ерөнхийлөгч зураглалсан. Гэвч инфляци одоогийн эрчээрээ явбал оны төгсгөлд 14 хувьд хүрч мэдэх нь. Харин Төвбанкны өөрсдийн тооцооллоос үзэхэд оны эцэст 12.1 хувь бууруу одоогийнхоос 0.9 нэгжээр буурахаар байна. Тэгвэл “Мандал Женерал Даатгал” компанийн шинжээчдийн харж буйгаар оны эцэст дээрх тоо 13-17.5 хувьд хэлбэлзэх төлөвтэй. ►

► Инфляцийг бараг л хоёр дахин бууруулна гэж Төвбанк “Төрийн мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-дээ тусгажээ. Төгрөгийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй тус байгууллага сүүлийн 10 жилд инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болно. Гэвч инфляци “зурхай”-гаа оноогүй нь их. Энэ нь мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй зарим ажил үр дүнгээ өгөхгүй байгааг илтгэх аж.

Гадаад валютын орох урсгах нэмэгдэхгүй, нөөц буурсаар буй. Гадаад валютын албан нөөцийн хэмжээ 1.3 тэрбум ам.доллар болж оны эхнээс 40 хувиар буураад байна. Энэ нь импортын 12.1 долоо хоногийн хэрэгцээ хангахаар байгаа аж. Иймээс мөнгөний нийлүүлэлтийг нэмж тэлэхээс Төвбанк зайлсхийж байгаа бөгөөд үүнийгээ 2015 оны мөнгөний бодлогод дурьджээ. Ингэснээр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-т ирэх онд Монголбанк тэргүүлэх үүрэгтэй оролцохгүй нь. Хоёр жилийн турш хэрэгжүүлсэн уг хөтөлбөрт олгох санхүүжилтээ цаашдаа багасгах нь. Харин орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийг авч үлдэх юм байна. Бусад хөтөлбөрийн зээлийг бууруулах замаар эдгээр хөтөлбөрөөс үе шаттай гарах зарчим Монголбанк баримталж байгаа аж. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Төвбанк Засгийн газартай хамтран таван дэд хөтөлбөр хэрэгжүүлсэн.

Монгол Улсын эдийн засгийн “эрүүл мэнд”-ийг илчлэх төлбөрийн тэнцэлд үүссэн хүндрэл энэ оны туршид үргэлжилж байгаа. Сүүлийн 1.5 жилийн хугацаанд төлбөрийн нийт тэнцэл 2.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарчээ. Энэ нь ДНБ-ий 23 хувьтай тэнцэх хэмжээ бөгөөд сар бүр дунджаар 150 сая ам.долларын алдагдал хүлээж байна. Үүнээс гадна энэ оны эхний найман сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/ ДНБ-ий ердөө найман хувьтай тэнцэх болов. Өөрөөр хэлбэл, хоёр жилийн өмнө ДНБ-ий 40 гаруй хувьд хүрч байсан

ГШХО 70 хувиар буураад байна.

Улсын зээлжих зэрэглэл уруудсан, томоохон төслүүдийн хэрэгжилт он дамнан удааширч байгаа нь мөнгөний бодлогын үр дүнд ч сөргөөр нөлөөлж эхэлсэн. Мөнгөний бодлогын үндсэн зорилт бодитой харагдахгүй байгаа нь олон нийтэд эргэлзээ төрүүлэх болсон. Өөрөөр хэлбэл, Монголбанкны мөнгөний бодлогод итгэх иргэдийн хүлээлт суларч байгааг МУИС-аас жил бүр гаргадаг “Хэрэглэгчийн итгэлийн индекс” судалгааны тайланд тэмдэглэжээ. Тус тайланд “Төвбанк бодитой зорилт дэвшүүлж, түүнийгээ

Экспортын түүхий эдийн үнэ сэргэхгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй, “Оюутолгой” төслийн гүний уурхайн хоёр дахь шатны санхүүжилт шийдэгдээгүй тохиолдолд мөнгөний бодлого “гар мухардах” талтай. Мөнгөний бодлогын хүүг нэмээд ч асуудал төдийлэн намжихгүй нь илэрхий.



биелүүлэхгүй бол инфляцийг удирдах боломж улам хомсдох эрсдэлтэй” хэмээн өгүүлсэн.

Шинэчлэлийн Засгийн газарт “тонгоруулсан” Монголбанк эрсдэлийн “өрөг” дээр нүүгээд эхэлсэн. Эхний нүүдэл нь УИХ-д оруулж ирсэн 2015 оны мөнгөний бодлого. Эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах нь уг бодлогын үндсэн зорилт. Түүнчлэн санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд болон урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэх нь оноогдсон үүрэг. Харамсалтай нь Монголбанкинд “ганцаарчилсан тоглолт” хийх боломжийг өнгөрсөн нэг жилийн хугацаанд засаг болоод цаг үе нь олгосонгүй. Тэд ч өөрсдөө эрсдэлийг сөрж, урагшаа давшилт хийсэнгүй.

Ирэх он Төвбанкны хувьд эдийн засгаа тогтворжуулах гарааны жил. Бодит хүндрэлтэй илүү нүүр тулах бэрх үе тохиохыг ч үгүйсгэх аргагүй. Үүнийг алдагдал багатай туулах хүнд “даалгавар”-ыг УИХ-аас өгч магадгүй. Гэхдээ экспортын түүхий эдийн үнэ сэргэхгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй, “Оюутолгой” төслийн гүний уурхайн хоёр дахь шатны санхүүжилт шийдэгдээгүй тохиолдолд мөнгөний бодлого “гар мухардах” талтай. Мөнгөний бодлогын хүүг нэмээд ч асуудал төдийлэн намжихгүй нь илэрхий.

Сангийн сайд Ч.Улаан “Засгийн газар ирэх онд иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2.5 дахин нэмэгдүүлнэ” гэж мэдэгдсэн. Энэ тохиолдолд инфляцийг нэг оронтой тоонд оруулна гэдэг мэдээж амаргүй. Төвбанк инфляцийг бууруулахаас гадна ажилгүйдлийг аль болох бага түвшинд байлгах ёстой. Тиймээс зөвхөн инфляци хэмээх өндөр үзүүлэлттэй “тулалдах” нь Монголбанкны хувьд илүү гарлагатай байж болох юм. Одоо ам.долларын ханш 1850 орчим төгрөгтэй тэнцэж байгаа. Үүний эсрэг Монголбанк тодорхой зорилтот бодлого хэрэгжүүлэхгүй гэдгээ үргэлж хэлдэг. Цаашдаа ч тэд ханш уян хатан тогтох ёстой гэсэн зарчмын байр сууриа хадгалсаар байх нь. ■

ЦАГ ҮЕ

# ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙНХЭН



Л.Пүрэвсүрэн



Р.Жигжид



Д.Зоригт



Н.Батцэрэг

## С.АЗ

УИХ намрын чуулганахаа хөшгийг нээсэн даруйдаа гүйцэтгэх засаглалын бүтцэд өөрчлөлт оруулахаар хагас сар гаруй хуралдаж байна. Засгийн газар хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ сайд нарын нэрийг давхар мэдүүлээгүй нь хугацаа алдах, энэ хооронд цаг хожиж хор найруулах, эцсийн дүндээ үүрэг гүйцэтгэгч сайд томилох нөхцөл байдал руу түлхэж байна гэдгийг УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, С.Баярцогт нар хэлж, багагүй бухимдсан. Ямартай ч Засгийн газар 13 яам, 11 тохируулагч агентлаг, 19 хэрэгжүүлэгч агентлагтай байхаар болж, Эрчим хүч, уул уурхайн яамыг нэгтгэж Уул уурхай, эрчим хүчний, Барилга хот байгуулалт, Зам тээврийн салбарыг нэгтгэн Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамтай байхаар баталсан. Мөн Эдийн засгийн хөгжлийн яамыг Сангийн яамтай нэгтгэв. Шинэчлэлийн Засгийн газар 16 яамтайгаар үйл ажиллагаа явуулж байсан нь нүсэр бүтцийг бий болгож, үргүй зардал гарган, эдийн засаг хүндрэхэд нөлөөлж байна хэмээн сөрөг хүчин өнгөрсөн хугацаанд шүүмжилж ирсэн. Н.Алтанхуяг

ч алдаагаа ухамсарлаж, бүтцээ цомхотгох шийдвэр гаргасан нь энэ юм. Тэрбээр “Чиг үүргийн давхардлыг арилгаж, ийм шийдвэр гаргасан гэдгээ” хэлж буй.

Түүний өргөн барьсан тогтоолын төсөлд Шадар сайд хоёр байхаар тусгаад байв. Өөрөөр хэлбэл, одоогийн шадар сайдын суудлыг Тэргүүн шадар болгож, шинээр бий болгох шадар сайдын харьяанд Гадаад харилцааны яамыг хариуцуулахаар боловсруулсан нь УИХ-аас дэмжлэг хүлээгээгүй. Тиймээс Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам нэртэй байхаар тогтлоо.

Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн талаар УИХ дахь олонхийн бүлгийн дарга Д.Эрдэнэбат “Эрчим хүч, Уул уурхайн яам хамгийн том төсөл хэрэгжүүлэгчид боловч хоорондын уялдаа холбоогүйгээс тендер шалгаруулалт удааширч байгаа. Мөн уул уурхай байгуулах газар эрчим хүч нь байх уу үгүй юу гэдгийг ч шийдэж чадахгүй байх болж. Энэ бол бүтэцтэй холбоотой байсан. Тиймээс нэгтгэх нь зөв” хэмээв.

УИХ гүйцэтгэх засаглалын бүтцийг

баталсны дараа ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэх учир “Асуудлаа хурдан оруулж ир” хэмээн “шахсан”. Нэгэнт хугацаа бага үлдсэн тул Засгийн газар УИХ-ын даргад шинээр томилох сайд нараа оройтсон ч гэсэн өргөн мэдүүллээ. Ингэхдээ Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайдад Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэн, Уул уурхай, эрчим хүчний сайдад Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Р.Жигжид, Сангийн сайдад УИХ-ын гишүүн, Ардчилсан намын “МҮДН” фракцийн Д.Зоригт гэсэн гурван сайдын нэрсийг өргөн мэдүүлсэн юм.

Харин “Шударга ёс” эвслээс томилогдох сайд нарын нэрсийг өргөн бариагүй. Ямартай ч тус эвсэлд өгөөд байсан Сангийн сайдын суудлаа АН өөрсдөө авахаар болж.

Тэгэхээр эвсэлд Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамаа өгнө гэсэн үг. Одоо “Шударга ёс” эвсэл тус яамыг хэн толгойлох вэ гэдгээ дотроо ярилцаж, шийдээ гаргана. Үүнтэй зэрэгцэн тус эвсэл Эрүүл мэндийн сайдыг солих гэж байгаа гэсэн яриа гарч эхэлсэн ч ▶▶

ОДООГИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
2. Гадаад харилцааны яам
3. Сангийн яам
4. Хууль зүйн яам
5. Барилга, хот байгуулалтын яам
6. Батлан хамгаалах яам
7. Боловсрол, шинжлэх ухааны яам
8. Зам, тээврийн яам
9. Соёл, спорт, аялал жуулчлалын яам
10. Уул уурхайн яам
11. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
12. Хөдөлмөрийн яам
13. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
14. Эдийн засгийн хөгжлийн яам
15. Эрчим хүчний яам
16. Эрүүл мэндийн яам

ШИНЭ БҮТЦЭЭР АЖИЛЛАХ ЗАСГИЙН ГАЗАР

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
2. Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам
3. Сангийн яам
4. Хууль зүйн яам
5. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
6. Батлан хамгаалах яам
7. Боловсрол, шинжлэх ухааны яам
8. Соёл, спорт, аялал жуулчлалын яам
9. Уул уурхай, эрчим хүчний яам
10. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
11. Хөдөлмөрийн яам
12. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
13. Эрүүл мэндийн яам

► Н.Удвал энэ удаад байрандаа үлдэх нь бололтой. Харин Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдад УИХ-ын гишүүн Ц.Цолмонгийн нэр дуулдаж байсан ч эвслийнхэн 100 хувийн саналаар бүлгийн дарга Н.Батцэрэгийг томилохоор нэгдсэн шийдэлд хүрчээ. Гэхдээ уг асуудлаа хараахан УИХ-аар хэлэлцүүлээгүй байна.

Ямартай ч АН албан тушаалын бялуугаа фракцууддаа эн тэнцүү хуваасан нь өргөн мэдүүлсэн төслөөс тодорхой харагдаж байна. Тодруулбал, Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнд МоАХ-оос Л.Пүрэвсүрэн, Ш.Түвдэндорж, Ц.Оюунгэрэл, “Шонхор”-оос Р.Жигжид, С.Эрдэнэ, “МҮДН”-ээс Д.Зоригт, Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ “Нэг ардчилал”-аас Х.Тэмүүжин, Л.Гантөмөр, “Алтангадас”-

аас Ч.Сайханбилэг, Я.Санжмятав нар багтаж байна.

Чуулган эхэлснээс хойш хоёр долоо хоног маргалдсан дээрх асуудлаа хурдан шийдэх байтал цөөнхийн болоод олонхийн бүлгийнхэн Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр оруулж ирсэн дээрх сайдуудын асуудалд ажлын тав хоногийн завсарлага авлаа. Хэдийгээр АН-ын Гүйцэтгэх зөвлөл удал ярилцсаны дүнд фракцууддаа эн тэнцүү суудал өгсөн ч МАН-ын бүлэг Уул уурхай, эрчим хүчний сайдад нэр дэвшигч Р.Жигдэд, Сангийн сайдад нэр дэвшигч Д.Зоригт нарын асуудлаар нэгдсэн шийдэлд хүрэхээр ирэх долоо хоног хүртэл хойшлуулж байна. Харин АН-ын бүлэг Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайдад нэр дэвшигч Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэнгийн асуудлыг дахин ярилцах шаардлагатай гэж үзэн завсарлага авсан нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн ийн сунжрахад хүрэв. Энэ үеэр УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр “Гадаад харилцааны сайдыг өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан юу вэ. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгддөг л юм байгаа биз. Яагаад Л.Болд сайдыг солих болов. Хоёрдугаар ээлжийнхэн хоолонд орох гэж байгаа юм уу. Ажлын хариуцлага алдсан тохиолдолд чөлөөлдөг. Гэтэл үндэслэл харагдахгүй байна. Төрийн албаар арилжаа наймаа шиг панз үсэргэдэг болоо юу. Хариулт сонсохыг хүсч байна” гэв. Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Манай бүх сайдууд маш сайн ажилласан. Дээр үеийнхээр бол гавшгайч болохоор ажиллалаа. Бодлого тодорхой болсон учраас бүтцийн өөрчлөлт хийж, яамдыг нэгтгэснээр сайдыг чөлөөлж байна. Танай намынхан өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төрийн алба нүсэр байна гэж их ярьсан. Төрөө цомхон бүтэцтэй болгохоор ажиллаж байна” хэмээлээ.

Ямартай ч сайдуудыг томилох асуудал аравдугаар сарын сүүл хүртэл үргэлжлэх нь. Нөгөөтэйгүүр яамдууд үүрэг гүйцэтгэгч сайдтай болж, ажил цалгардах нөхцөл байдал үүсч мэдэхээр байгаа юм. Тиймээс намын бүлгүүд энэ асуудалд шил шилээ харалгүйгээр хурдан шийдэж, 2015 оны төсөв, мөнгөний бодлогоо даруйхан баталж, тодотголоо хийх нь чухал болоод байна. Нөгөөтэйгүүр Засгийн газрын бүтцэд ийн хоёр жилийн дараа өөрчлөлт оруулж байгаа ч нэмэгдэхүүний байрыг солилоо ч нийлбэрийн чанар өөрчлөгдсөнгүй. Олонх болсон улс төрийн хүчин нам доторх фракцуудынхаа тохироог зөв хийж, асуудлыг хурдан шийдээгүйгээс улс орны амин чухал асуудлууд хойшилсоор байна. ■

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

# ЧИНГИС БОНДЫН ЗАРЦУУЛАЛТ

**С.АЗ**

Чингис бондын хөрөнгийг ямар компаниудад өгсөн нь олон нийтэд төдийлэн ил бус байгаа. Тиймээс манай сэтгүүл Чингис бондоос ямар аж ахуйн нэгж хэдэн төгрөгийн зээл авсныг цувралаар хүргэж буй. Өмнөх дугаарт хөдөө аж ахуйн салбар болон “Гудамж” төслийн зарцуулалтын талаар мэдээлсэн. Мөн эрчим хүч

болоод барилгын салбарт хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хэчнээн компанид хэдэн төгрөг өгснийг дэлгэрэнгүй нийтэлсэн билээ. Түүнчлэн аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбоход гүйцэтгэгчээр ажиллаж буй компаниудын жагсаалтыг хүргэсэн. Харин энэ удаа уул уурхай болон дэд бүтцийн төслүүдийн талаар нийтэлж байна.

**Эрдэнэс тавантолгой**

сая ам.доллар

Хэрэгжүүлэгч	Эрдэнэс ТТ ТӨК
Тогтоолоор батлагдсан дүн	200,0
Гэрээний дүн	200,0
Олгосон дүн	200,0
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэлийн хувь	100%

**Багануур**

тэрбум төгрөг

Хэрэгжүүлэгч	Багануур ХК
Тогтоолоор батлагдсан дүн	?18.6
Гэрээний дүн	?18.4
Олгосон дүн	?18.3
Эргэн төлөлтийн дүн	?1.8
Ажлын гүйцэтгэлийн хувь	100%

**Нийслэлийн инженерийн шугам, дэд бүтцийн төслүүд**

тэрбум төгрөг

Хэрэгжүүлэгч	ЭХЯ, БХБЯ, НЗДТГ
Тогтоолоор батлагдсан дүн	Т 200,0
Гэрээний дүн	Т 196,4
Олгосон дүн	Т 101,8
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	76.0%

**Дэд бүтцийн төслүүд**

тэрбум төгрөг

Хэрэгжүүлэгч	ЭХЯ, БХБЯ
Тогтоолоор батлагдсан дүн	Т 3,4
Гэрээний дүн	\$ 2,2
Олгосон дүн	\$ 2,1
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэлийн хувь	100.0%

**ЖДҮ хөгжүүлэх сан**

тэрбум төгрөг

Хэрэгжүүлэгч	ЖДҮХС
Тогтоолоор батлагдсан дүн	50,0
Гэрээний дүн	50,0
Олгосон дүн	48,5
Эргэн төлөлтийн дүн	1,6
Ажлын гүйцэтгэлийн хувь	97%

**Сайншанд АҮЦ**

тэрбум төгрөг

Хэрэгжүүлэгч	ҮХААЯ
Тогтоолоор батлагдсан дүн	14,2
Гэрээний дүн	9,2
Олгосон дүн	6,3
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэлийн хувь	-

**ТЭЦ-4 хүчин чадал нэмэгдүүлэх**

сая ам.доллар

Хэрэгжүүлэгч	ЭХЯ
Тогтоолоор батлагдсан дүн	70,0
Гэрээний дүн	70,0
Олгосон дүн	44,1
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэлийн хувь	46%

**ТЭЦ-3 хүчин чадал нэмэгдүүлэх**

сая ам.доллар

Хэрэгжүүлэгч	ЭХЯ
Тогтоолоор батлагдсан дүн	35,0
Гэрээний дүн	35,0
Олгосон дүн	28,0
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэлийн хувь	86,2%

**ЖДҮ хөгжүүлэх сан /салбараар/**

тэрбум төгрөг

Салбар	Төслийн тоо	Олгосон зээлийн дүн	Эзлэх хувь
Барилга	32	12.6	26.0%
Хүнсний үйлдвэр	18	6.9	18.6%
Био нано технологи	3	1.0	2.0%
Хөнгөн үйлдвэр	24	5.4	10.9%
Ногоо, махны зоорь	4	4.1	8.4%
Мал аж ахуй	15	3.5	7.5%
Газар тариалан	7	2.6	5.3%
Худалдаа үйлчилгээ	12	1.5	3.1%
Бусад (тулш, цэцэрлэг, хэвлэл г.м)	28	10.9	18,1%
<b>Нийт</b>	<b>143</b>	<b>48.5</b>	<b>100%</b>



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

Манайд өнөөдрийн байдлаар 1905 км төмөр зам байгаагаас 1807 км-ыг нь Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗ компани эзэмшиж буй.

## ДЭД БҮТЭЦ

# ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР

### С.ЗАЯА


Чиргүүлтэй ачааны машинаар нэг удаадаа 140 тонн ачаа зөөх бол галт тэрэг 10 мянган тонн-ыг зөөх хүчин чадалтай. Энэ үүднээс нь харвал, төмөр замыг хөгжлийн хурдасгуур гэж хэлж болох нь. Тэгэхээр манайх 6-7 жил ярин, маргалдаж буй төмөр замын царигийн асуудлаа хурдан шийдэж, яаралтай урагшлуулах нь чухал болоод байна. Үүнийг өнгөрсөн найм, есдүгээр сард манай улсад айлчилсан хоёр хөршийн төрийн тэргүүн сануулсан.

УИХ-аас 2010 онд “Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого”-ын баримт бичиг баталсан. Үүнээс хойш дөрвөн жил гаруйн хугацаа өнгөрсөн ч Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн 225 км төмөр замын газар шорооны ажлыг эс тооцвол бусад чиглэлд нэг ч хүрз шороо байрнаас нь хөдөлгөсөнгүй. Тавантолгойгоос Гашуунсухайт, Сайншандаас Замын-Үүд, Хөөтөөс Бичигт хүртэл нарийн царигтай, Тавантолгойгоос Сайншанд, Хөөт-Чойбалсан Нөмрөг буюу Дорнод аймаг руу гардаг зам болоод Эрдэнэт-Могойн голын хил хүртэлх 550 км замыг өргөн царигтай тавихаар тусгасан нь улстөрчдийн халуун сэдвийн нэг болоод байна. Энэ талаар УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан “БНХАУ-ын дарга Си Зиньпин өнгөрсөн наймдугаар сард манай улсад төрийн айлчлал хийхдээ олон гэрээ хэлэлцээр хийсний нэг нь манай улс далайд гарах гарцтай болсон явдал. Тиймээс бид дотооддоо асуудлаа яаравчлан шийдэх хэрэгтэй. Манай улс дэлхийн төмөр замын зах зээлд байр сууриа алдаж байгаа учир төмөр замын тээврийн бодлогоо түргэтгэх шаардлага байгаа” гэв.

Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн 225 км төмөр замын газар шорооны ажил аравдугаар сарын 6-ны байдлаар 78.4 хувьтай байна. Тус зам 2015 онд ашиглалтад орсноор дотоодын төмөр замын нийт хүчин чадал жилд 30 сая тонн, 2020 онд 67 сая тонн болж өсөх юм. Монголын анхны төмөр зам 1950-иад онд ашиглалтад орж байж. Манайд өнөөдрийн байдлаар 1905 км төмөр зам байгаагаас 1807 км-ыг нь Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗ компани эзэмшиж буй. Эдгээрт 15 мянган хүн ажилладаг. Тэгвэл зөвхөн зүүн чиглэлийн төмөр ➤

1 Нэг км төмөр зам барих өртөг /сая ам.доллар/

МОНГОЛ	////////////////////	2.5-3.2
АВСТРАЛИ	////////////////////	3-4
ИНДОНЕЗИ	////////////////////	3-4
ЛИВИ	////////////////////	4.7
НИГЕР	////////////////////	4.3



► зам ашиглалтад ороход ийм тооны хүнийг ажлын байраар хангах тооцоог "Монголын төмөр зам" төрийн өмчит компани хийжээ.

Манай улс 2012 онд төмөр замаар 20.4 сая тонн ачаа тээвэрлэжээ. Харин Ерөнхий сайд өнгөрсөн онд БНХАУ-д айлчлал хийхдээ жилд 50 сая тонн нүүрс экспортлох гэрээ хийж байв. Тиймээс ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлж, экспортын гарцыг нээх, стратегийн ордуудаа төмөр замаар холбох, нэгдсэн сүлжээтэй болох асуудал тулгарч буй. Энэ хүрээнд ирээдүйд Монгол Улсад нийт 5600 км төмөр зам тавихаас эхний ээлжинд Тавантолгойн бүлэг орд, Цагаан суваргын зэсийн ордыг дайруулж, Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор хүргэх төмөр замын сүлжээ бий болгож. Түүнийгээ цаашид хоёр гарцтай болгох чиглэл баримталж байгаа аж.

Ингэснээр экспортын гарцыг Хятад, Орос руу нэмэгдүүлэх боломжтой. Мөн далайн боомтууд руу хүрэх шинэ гарцуудыг нээж байна. Энэ нь гурав дахь зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд илүү хялбар болох юм. Өөрөөр хэлбэл, гангийн хэрэгцээ, коксжих нүүрсний хэрэглээ өндөртэй Япон, Солонгос руу бүтээгдэхүүнээ экспортлох боломж бүрдэнэ гэдгийг Зам тээврийн яамны удирдлагууд хэлсэн. "Шинэ төмөр зам" төсөл Хятадын хамгийн их нүүрсний хомсдолтой хэсгийг түүхий эдээр хангах гарцыг бий болгох ач холбогдолтой гэх. Тодруулбал, 2020 он гэхэд Хэбэй мужид 85 сая, Ляонин мужид 30 сая тоннын нүүрсний хомсдол, эрэлт бий болно гэх тооцоо байдаг аж. Энэ хоёр муж Хятадын төмрийн үйлдвэрлэлийн гол бүс юм байна. Гэхдээ Гашуунсухайтаар бүтээгдэхүүнээ экспортлох, Хятадын нутгаар дамжаад Хэбэй мужид очих уу, Монгол Улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэж, Бичигтийн боомтоор гарч, Хэбэй, Ляонин мужид очих уу гэдгийг шийдэх хэрэгтэй байгаа аж.

Мөн Япон улсад 2020 он гэхэд 40, Солонгост 15 сая тонн нүүрсний эрэлт бий болно. Үүнийг хангах бололцоо бүрдэнэ гэдгийг "Монголын төмөр зам" компанийнхан хэлж буй юм. 1800 км төмөр зам барихад урьдчилсан тооцоогоор 5.2 тэрбум ам.доллар хэрэгтэй байгаа аж. Энэ нь манай улсын төсвөөс ч их мөнгө. Тиймээс гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татахаас өөр аргагүйд хүрчээ. Энэ хүрээнд олон улсад нээлттэй тендер зарлаж. Уг төсөлд оролцохоор 12 орны 20 компани саналаа ирүүлсэн байна. Үүний 10 компанитай нь хэлэлцээр хийж эхэлсэн байна. Нийт шаардлагатай хөрөнгийн 60 хувийг нь хөрөнгө оруулагчаас татахаар Зам тээврийн яамныхан тооцоолжээ. Оруулсан нийт хөрөнгө оруулалтыг 9.2 жилд нөхөх тооцоог ч хийж.

Ямартай ч эхний Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг ирэх онд ашиглалтад оруулахаар ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын "Самсунг" корпорацитай ажиллаж байна. Энэ зам ашиглалтад орсноор Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж буй дэлхийд дээгүүрт бичигдэх Тавантолгой, Оюутолгойн ордоос гарч буй бүтээгдэхүүнийг урд хөрш рүү галт тэргээр зөөж, цаг хугацаа хэмнэхээс гадна Монголын эдийн засагт томоохон түлхэц болох юм.

- 2013 оны хоёрдугаар сарын 28-нд Төрийн өмчийн хорооны 55 тоот тогтоолоор "Шинэ төмөр зам" компанийг байгуулж, компанийн дүрмийг баталсан.
- Ерөнхий сайдын 2012 оны 65 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг шинээр баригдах төмөр замын төслийн тусгай зориулалтын компанийн 49 хувьд гадаад, дотоодын хувийн хэвшлээс хөрөнгө оруулах.
- 2013 оны аравдугаар сарын 25-нд Монголын талын Гашуунсухайт өртөөг Ганцмод боомттой холбох хүнд даацын төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэхэд "Монголын төмөр зам" ТӨХК-тай хамтран ажиллахаар БНХАУ-ын төрийн өмчит "Шэнхуа Групп Корпораци", "Эрдэнэс Таван Толгой" ТӨХК, "Энержи Ресурс" ХХК, "Таван Толгой" ХК-ийн бүрэлдэхүүнтэй Консорциум болон Шэнхуа Групп Корпорацитай хамтран ажиллах санамж бичиг зурсан.
- "Samsung C&T" компанийн боловсруулсан ажлын зургийн эхний хэсгийг 2013 оны арванхоёрдугаар сард Зам, тээврийн яамны экспертүүд баталсан. Бусад ажлын зургийг батлуулах ажил явагдаж байна.

Манай эрх баригчид ОХУ-ын буюу 1520 мм-ийн өргөн, Хятадын 1435 мм-ийн буюу нарийн царигийн алинаар нь барих уу хэмээн сүүлийн хэдэн жил маргалдсан. Одоо ч мөн адил. Энэ асуудалд "Монголын төмөр зам" компанийн төслийн багийнхан "Цариг яаж шийдэгдэх нь чухал биш. Хамгийн гол нь, ойр ойрхон өөрчлөгдөөд байх нь төслийн явцад хор уршигтай. Төмөр зам барих нь автомашинаар зөөснөөс хамаагүй бага зардал гарна. Тиймээс төмөр замаа хурдан баримаар байна" хэмээсэн. Тиймээс манай улс хөгжлийн хурдасгуур төмөр замын төслүүдээ цаг алдалгүй урагшлуулах нь юу юунаас илүү чухал байна. Үүнийг хөдөлгөх гол хүч нь улс төрийн шийдвэр болчихоод байна. ■

## ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ-НҮҮРС

## ШИНЭЧЛЭЛИЙГ ТОЛЬДВОЛ

## Б.ҮҮРИЙНТУЯА

Засаглалын “зэмсгүүдийг” ашиглан тогтвортой хөгжлийг цэцэглүүлэх боломж бий. Ингэхдээ Засгийн газрууд татвар хэмээх уламжлалт сонголтыг урдаа барих нь элбэг ч энэ нь бүхний шийдэл гэвэл өрөөсгөл болохыг олон улсын судлаачид өгүүлдэг. Хэдий ийм ч татварын аргачлал аливаа улсын санхүүгийн асуудлыг шийдвэрлэгч “сонгодог” арга хэвээр байна.

Дэлхийн хамгийн том эдийн засаг гэгдэх болсон Хятад улсын тулах багана нь эрчим хүч. Эрчим хүчний эх үүсвэр нь нүүрс. Үндсэндээ урд хөршийн хувьд нүүрс тус улсын эдийн засгийн “хүчил төрөгч” гэсэн үг. Тиймээс Засгийн газар нь эрчим хүч, нүүрсний салбартаа тусгайлан бодлого гарган, түүнийгээ чандлан мөрддөг. Ингэхдээ татварын нарийн бодлогод суурилан дээрх салбаруудаа дэмжин, хөгжүүлдэг байна. Урд хөршид эрчим хүчний татварын тогтолцоо 1984 оноос эхлэлтэй. Улмаар 1994 онд шинэчлэл хийн нүүрс, газрын тос, байгалийн хий болон бусад эрдсийг багтаан нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Өдгөө Хятадын эрчим хүчний татвар зах зээлийн үнэлгээ гэхээсээ илүү олборлож буй хэмжээгээр тодорхойлогддог. Түүнчлэн татварын орлого засагт бус олборлолт явагдаж байгаа бүс нутгийн захиргаанд очдог аж. Сүүлийн жилүүдэд газрын тос болон байгалийн хийн салбарт татварын шинэчлэл хийж улс даяараа хэрэгжүүлэх болсон ч нүүрсний салбарт ийм төрлийн шинэчлэлийг саяхнаас хэрэгжүүлэхээр баталлаа.

Нүүрс нь Хятадын аж үйлдвэр, шинэчлэл, шилжилтийн чухал үндэс. Тус улсын хөгжил олон жилийн турш нүүрснээс хамааралтай байсан гэж болно. Тухайлбал, 2012 онд

Америкийн “Energy Information Administration”-ээс гаргасан судалгаанд урд хөршийн эрчим хүчний нийт хэрэглээний 70 хувийг нүүрс бүрдүүлдэг бол цахилгааны 60 хувийг хангадаг гэжээ. Түүнчлэн Хятадын эрчим хүчний хэрэглээний бүтцэд нүүрс гол тоглогч байх бөгөөд энэхүү байдлаа олон жил хадгална хэмээн дүгнэжээ. Энэ нь нүүрсний хэрэглээ Хятадын эрчим хүчний аюулгүй байдал, тогтвортой өсөлтийн “амин сүнс” гэдгийг гэрчилж байгаа юм.

Хятадын эдийн засаг нүүрсний үнийн хэлбэлзэлд өртөмтгий. Тус улсын нүүрсний салбарын хөгжил нийгэмд ижил түвшинд хүлээн зөвшөөрөгддөггүй. Өөрөөр хэлбэл, нийгмийн ашиг тус нь нийгмийн зардалтай ижил бус. Хэдий эдийн засгийн өсөлтийг дэмжигч боловч байгаль орчин, агаарын бохирдлын гол үүсгэгч гэсэн үг. Ийм учраас нүүрстэй холбоотой асуудал үргэлж маргаан дэгдээдэг байна.

Хятадын нүүрсний зах зээл үнийн хэлбэлзэлд удаан “дарлуулсан”. Бага бөгөөд тогтсон татварын системээр дэмжих боломж бий ч энэ нь олборлох, хэрэглэх явцад гарах байгалийн бохирдлыг зах зээлийн ханшид багтаан тооцдоггүй. Түүнчлэн Хятадын нүүрсний салбар төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжсэн гэх боловч тус улсын нүүрсний зах зээлийн ханш улсын нүүрсний нөөцийн хомсдлын талаар тодорхой мэдээлэл өгдөггүй аж.

Хятадын Засгийн газрын нүүрсний үнэ тогтоох механизм нь тус улсын эдийн засаг болоод нүүрс үйлдвэрлэлийн тэнцвэртэй бас тогтвортой хөгжлийн чухал хэсэг гэж үздэг ч нүүрсний татварын шинэчлэл нь хөгжлийн эх үндэс хэмээх болов. Шинээр

батлагдаад буй Хятадын нүүрсний салбар дахь татварын шинэчлэлээр татварыг үйлдвэрлэлийн хэмжээнээс бус ханшийн үнэлгээнээс тооцон хураахаар болж байгаа юм. Энэхүү шийдвэрийн гол зорилго нь улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хэт их үйлдвэрлэлийг хянах, нөөцөө хадгалах болон татварын эх үүсвэрийг алдалгүйгээр байгаль орчноо хамгаалахад оршиж байна.

Эрчим хүчний салбарынхан Засгийн газар эрчим хүчний үнийг чөлөөлөхгүй аваас татварын шинэчлэлийн эсрэг зогсох нь дамжиггүй. Үүний эсрэг хянан тодорхойлогч тал хэмээгдэж буй Засгийн газар төсвийн орлого, эрчим хүчний аюулгүй байдал, нүүрсний нөөц дуусах эрсдлийг харгалзан шинэчлэл хийх нь зайлшгүй гэж үзэж байна.

Шинэчлэл бүр шалгууртай нүүр тулдаг. Тэгвэл энэ удаагийн татварын шинэчлэл хэнд ямар ашигтай байх вэ гэдэг сонин. Хятадын хувьд тус салбарт үндсэн гурван тоглогч бий. Төв Засгийн газар, орон нутгийн захиргаа тэгээд зах зээл. Эдгээрийн хүсэл сонирхолд нийцсэн нэгдсэн үнэт чанарыг баримтална гэдэг амаргүй. Хэрэглэгч, нийлүүлэгч, хянагч талд тус бүр ашигтай хувилбар гаргах асуудлыг тус улсын Засгийн газар ийн зохицуулж. Нийлүүлэгч гэх нүүрсний компаниуд хэрэглэгч гэгдэх эрчим хүчний компаниудад хянагчийн үүрэг ▶

► гүйцэтгэх Засгийн газрын тогтоосон журмаар бүтээгдэхүүнээ хүргэнэ.

Хятадын нүүрсний компаниудын дийлэнх нь төрийн өмчит хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлдэг. Бусад нүүрсний компани бизнесийн зарчмаар ашиг олдог. Тиймээс төрд харьяагүй компаниуд татварын дарамтаар үйл ажиллагааг нь боомилохыг хэрхэвч зөвшөөрөхгүй байсан. Тэгвэл хэрэглэгч гэгдэх нүүрсээр “хооллогч” эрчим хүчний компаниудын хувьд татвараас үүдэлтэй үнийн өсөлт цахилгааны ханшийг өсгөхөөс өөр гарцгүй болгоно. Гэвч тэдэнд эрчим хүчний үнийг нэмэх эрх мэдэл үгүй билээ. Учир нь төв Засгийн газар цахилгааны үнийг тогтоодог аж. Иймд эрчим хүчний салбарынхан Засгийн газар эрчим хүчний үнийг чөлөөлөхгүй аваас татварын шинэчлэлийн эсрэг

экологийн асуудалд тодорхой хувь нэмэр оруулж байна гэж үзэх хэсэг ч бий болжээ.

Урд хөршийн нүүрсний нөөц жигд бус тархсан байдаг. Ийм учраас орон нутгийн хувьд хэрэглэгч, олборлогч гэж хувааж болох тухай дурджээ. Хятадын нүүрсний олборлолтын 80 хувийг бүрдүүлэгч найман муж байдаг(баруун бүсийн долоо, төвийн нэг). Эдгээр муж эрчим хүчний эдийн засагтай гэгдэх бөгөөд улсын төсвийн болон ДНБ-ий орлого бүсээс ирэх эрчим хүчний аж үйлдвэр болон эрчим хүчний татварын орлогоос бүрддэг байна. Өмнө нь хэрэгжиж байсан татварын тогтолцоогоор Засгийн газрын орлого хэтэрхий бага байсан гэж төрийн удирдлагууд үзсэн бол шинэчлэл хэрэгжсэнээр эрчим хүчний татвараас төсөвт төвлөрөх орлогоор бусад

хүчний үнийн өөрчлөлтийг Засгийн газар зохицуулдаг. Хэрэв нүүрс, эрчим хүчний салбарынхан үнийн зөвшилцөлд хүрч чадахгүй аваас амьжиргааны өртөг нэмэгдэх, цаашлаад зах зээлийн үнийн хэлбэлзэл үүсэх эрсдэлтэйг Баруун Австралийн их сургуулийн Хөдөө аж ахуй, эрдэс баялгийн эдийн засгийн сургуулийн багш Донг Ванг “Хятадын нүүрсний татварын шинэчлэлийн зөрчилдөөн дэх дүн шинжилгээ”-ндээ өгүүлжээ. Тэрбээр “Нүүрс олборлогч бүсийн хувьд татварыг нэмсэн нь үйлдвэрлэл цаашид хөгжих, ажилгүйдлийн түвшин буурах, татварын болон ДНБ-ий орлого нэмэгдэх таатай нөхцөл болно” гэв. Харин хурдацтай өсөх нүүрсний үйлдвэрлэл нөөцийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй болохыг тэрбээр онцолсон.



зогсох нь дамжиггүй.

Үүний эсрэг хянан тодорхойлогч тал хэмээгдэж буй Засгийн газар төсвийн орлого, эрчим хүчний аюулгүй байдал, нүүрсний нөөц дуусах эрсдлийг харгалзан шинэчлэл хийх нь зайлшгүй гэж үзэж байна. Ингэснээр эрчим хүчний компаниудын төлөх татварын хэмжээ нэмэгдэж байгаа юм. Хэдийгээр нүүрс олборлогчдын үйлдвэрлэлийг хумиж байна гэж буй ч үйлдвэрлэл хэт тэлэх эрсдлийг бууруулна хэмээн зарим судлаач онцолж байгаа билээ. Зарим талаар

хөгжлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх нөхцөл бүрдэнэ гэсэн байна. Харин нүүрс хэрэглэгч мужуудын захиргааны хувьд татварын орлогыг орон нутагт жигд хүртээх нь зөв шийдэл, учир нь ингэснээр хэрэглэгч бус нүүрсний хэрэглээнээс үүдэх хор уршигтай тэмцэх санхүүжилт, боломж бий болно гэж үзсэн.

Татвар нэмэгдвэл үнэ нэмэгдэнэ. Нүүрсний үнэ нэмэгдсэнээр эрчим хүчний ханшид өөрчлөлт орж эрчим хүчний компаниуд алдагдал хүлээж эхлэх аж. Учир нь эрчим

Нөгөө талд нүүрсний ханш өсвөл нүүрс хэрэглэгч мужуудын эдийн засгийн үндэс болдог үйлдвэрлэлийн салбар уналтад орох эрсдэл хүлээх аж. Түүнчлэн ажилгүйдэл ихсэх, эдийн засгийн чадамж буурах гээд таагүй нөхцөл ар араасаа үүсэх магадлал өндөр юм.

Хятадын эрчим хүчний салбарыг гардан хариуцсан байгууллага, яам гэж байдаггүй. Нүүрсний үйлдвэрлэлийн яам нь 1998 онд татан буугдсанаас хойш тус салбарын асуудал “хоног төөрүүлэх” мэт агентлаг, газруудын гараар дамжсаар өнөөдрийг хүрчээ. Хятадын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо, Улсын татварын ерөнхий газар, Улсын төрийн өмчит хөрөнгө хянах, удирдах хороо зэрэг байгууллагууд урд хөршийн нүүрсний салбарын бодлогыг базаж явна. Тэд ч мөн ашиг сонирхлын зөрчилд өртөх тул Эрчим хүчний яам яаравчлан байгуулах нь зөв хэмээн Донг Ванг зөвлөж байгаа юм. Энэ мэт сонирхлын зөрчлүүд гарсаар байх аж.

Одоо Хятадын хэрэгжүүлэх татварын шинэчлэл хожил авчрах эсэхийг харах л үлдлээ. Тоглогч олонтой энэ салбарын зураглалыг бүхний таалалд нийцүүлнэ гэдэг үлгэр. Харин үүнийг хэрхэн шийдэж, ашигтайгаар даван туулах вэ гэдэг урд хөршийн Засгийн газрын “уран ухаанд” үлдэг. ■

## ЭКСПОРТ

# ЭКСПОРТЫГ ӨНГӨЛЖ БУЙ ОЮУТОЛГОЙ

## Б.ТОГТОХ

“Оюутолгой” компанийн борлуулалт энэ улиралд өссөн дүнтэй гарсан. Ингэснээр энэ онд үйлдвэрлэсэн нийт баяжмалын хэмжээ 377 мянган тонн боллоо. Хэрэв баяжуулах үйлдвэрийн хаягдал өтгөрүүлэх хоёр байгууламжийн нэгд гэмтэл гараагүй бол дээрх хэмжээ илүү өндөр байхыг үгүйсгэх аргагүй юм. Уг байгууламжийг засах хугацаанд баяжуулах үйлдвэр хүчин чадлынхаа 60 хувиар ажилласан аж. Хэдий баяжуулах үйлдвэрийн хүчин чадал багассан ч өндөр агуулгатай хүдэр боловсруулсан байна. Энэ нь өмнөх улиралд үйлдвэрлэсэн баяжмал дахь металлын агуулгын хэмжээнээс хол зөрүүгүй болохыг тус компанийн Санхүү хариуцсан захирал Стив Дугган онцлон тэмдэглэсэн. Энэ улиралд Оюутолгойн борлуулалтын хэмжээ үйлдвэрлэлээс давсан. Агуулга буураагүй нь хүдрийн агууламж өндөртэй хэсэгт олборлолт явуулж байгаатай холбоотой аж.

Борлуулалтын гэрээг энэ оныг дуустал байгуулсан тул оны сүүлийн хагаст 471.9 мянган тонн зэсийн баяжмал экспортлох төлөв бий. Улмаар агуулах дахь борлуулагдаагүй нөөц буурахаар байгаа юм. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын өсөлтийн тав орчим хувийг “Оюутолгой” компани бүрдүүлэх нь. Ирэх онд тус компани 850.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх аж. Ингэснээр 856.8 мянган тонн зэсийн баяжмал экспортлох төлөвлөгөөтэй байна.

Монголын экспортлогчдын холбооны тэргүүн Д.Галсандорж эдийн засгийн өнөөгийн хүндрэлтэй холбогдуулан “Монголын эдийн засгийг ирэх 10 жилд зэс “үүрч” явна” хэмээн шинэ дүгнэлт хийсэн. Түүний харж буйгаар нүүрс, төмрийн хүдрийн экспорт ирэх жилүүдэд улам багасах нь. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр энэ оны есдүгээр сарын байдлаар нүүрс, цайрын баяжмал зэрэг түүхий эдийн олборлолт буурчээ. Өмнөх жилүүдэд төсвийн орлогыг бүрдүүлж байсан нүүрс, төмрийн хүдэр, жонш зэрэг голлох нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оныхоос 22 хувиар буурсан байна. Энэ нь цаашдаа экспорт их хэмжээгээр хийгдэх боломжгүйг харуулах аж.

Оюу толгойн үйлдвэрлэлийн үзүүлэлт	2014 оны 3-р улирал	2014 оны эхний 9 сар
Боловсруулсан хүдэр ('000 тонноор)	7,029	20,367
Бутлагч руу орох хүдрийн дундаж агуулга (хүдрийн агуулга)		
Зэс(%)	0.59	0.55
Алт (r/t)	0.80	0.64
Мөнгө (r/t)	1.64	1.58
Үйлдвэрлэсэн зэсийн баяжмал ('000 тонноор)	134.1	377
Баяжмалын дундаж агуулга (% Зэс)	27.3	26
Үйлдвэрлэсэн баяжмал дахь металл		
Баяжмал дахь зэс ('000 тонноор)	36.	98.2
Баяжмал дахь алт ('000 унциар)	132	311
Баяжмал дахь мөнгө ('000 унциар)	216	608
Борлуулсан баяжмал дахь металлууд		
Баяжмал дахь зэс ('000 тонноор)	53.6	118.3
Баяжмал дахь алт ('000 унциар)	144	298
Баяжмал дахь мөнгө ('000 унциар)	323	710

Эх сурвалж: [www.ot.mn](http://www.ot.mn)

Манай улсын экспортыг өнгөлж буй нь зэс. Дэлхийн эдийн засагт “доктор” хэмээн тоогдох уг металл Монголын эдийн засагт ч онцгой үүрэг гүйцэтгэх нь. Ирэх онд тонн тутмын үнэ нь харьцангуй тогтвортой байх уул уурхайн түүхий эдээр зэс тодорч буй. Тонн нь 7008 орчим ам.долларт хүрээд буй зэсийн зах зээл нийлүүлэлтийн илүүдэлтэй байгаа. Энэ нь 2015 онд зэсийн үнэ төдийлэн өсөхгүй хэмээн үзэхэд хүргэсэн.


Дэлхийн нийт цэвэршүүлсэн зэсийн хэрэглээний 45 орчим хувийг дангаар эзэлдэг Хятадын дотоод эрэлт ч тийм сайнгүй яваа. Энэ нь зэс гурван жилийн өмнөх түүхээ давтаж чадахгүй нь гэсэн “хариулт” юм. Гэхдээ дэлхийн түүхий эдийн зах зээлд үнэ нь тогтвортой металл зэс болохыг шинжээчид хүлээн зөвшөөрсөн. Монголын нийт экспортын 81.6 орчим хувийг бүрдүүлдэг уул уурхайн экспорт ирэх онд нийт дүнгээрээ багасах төлөв бий. Өнгөрсөн хугацаанд салбарын экспорт өсөхөд газрын тос болон “Оюутолгой” компанийн экспортын хэмжээ эрс нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж буй. Ирэх онд ДНБ-ий бодит өсөлт 7.1 хувьтай гарахад Оюутолгойн зэс жинтэй хувь нэмэр оруулах бололтой. ■

ХӨРШ

# АЗИЙН НАЙДВАР

## Б.БАЯРТГОХ

Бүс нутгийн хөгжлийг тодорхойлж буй БНХАУ-ын эдийн засгийн өсөлт энэ онд шинэ амжилт тогтоож чадахгүй нь. Тус улсын эдийн засаг дотоод эрсдэлээс шалтгаалан ДНБ-ий бодит өсөлт нь буурах магадлал өндөр байгааг олон улсын шинжээчид тэмдэглэх боллоо. Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын идэвхжил буурснаас шалтгаалж дотоодын хөрөнгө оруулалт саарсан байна. Мөн банкны зээлийн чанар муудаж байгаа нь олон улсын худалдаа болон түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлөх бололтой. Энэ нь нүүрсний үнэ ирэх онд дахиад л сэргэхгүй гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэж байна.



Хятадын ДНБ-ий бодит өсөлт 2015-2016 онд долоо орчим хувьтай байна гэсэн судлаачдын урьдчилсан таамаг гарчээ. Энэ оны хоёрдугаар улиралд 7.5 хувиар өссөн эдийн засаг оны төгсгөлд долоон хувь руу “гулсаж” магадгүй нь. Өөрөөр хэлбэл, сүүлийн гурван жил долоон хувиас доош унаагүй зах зээл ирэх онд ч мөн адил өмнөх түүхээ давтах бололтой. Урд хөршийн эдийн засаг хэчнээн хүнд байдалд орсон ч 7.3 хувиас доош буухгүй гэж зарим гаднын эдийн засагчид үзэж байгаа юм.

Өмнөд хөрш санхүүгийн зах зээлээ чөлөөлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн үргүй зардлыг бууруулах зорилт дэвшүүлж буй. Түүнчлэн экспортоос дотоодын хэрэглээг урамшуулахад шилжих замаар эдийн засгийн өсөлтийн загвараа өөрчилж байгаа. Үүнээс үүдэн аж үйлдвэрлэлийн өсөлт удааширч эхэлсэн. Үйлдвэрлэгч

орны хувьд экспорт буурах нь томоохон эрсдэлийг дагуулдаг. Гадаад зах зээлийн эрэлт буюу Европ, АНУ-ын худалдан авалт сул байгаа нь Хятадын гадаад худалдааны эргэлтэд хатуухан цохилт өгөх болсон. Гэхдээ импортын өсөлт 10 гаруй хувьтай байгаа нь дотоодын эрэлт өндөр байгааг илтгэх аж. Энэ нь экспортоос ирж буй дарамтыг зөөлрүүлж байгаа юм.

Хятадын Засгийн газар энэ онд зээлийн өсөлтийг хязгаарлах бодлого баримтлах болсон. Энэ нь эрэлтийг бууруулж, инфляцийг нам түвшинд хадгалах боломж олгож буй. Гэхдээ өмнөд хөршид инфляцийг өдөөх хүчтэй эрэлт үүсэх боломжгүй гэдгийг тус улсын нөлөө бүхий 10 эдийн засагчийн нэгээр шалгарч байсан Лан Шэнь Пин дэлхий нийтэд “илчилсэн”. Энэ нь нэг цагийн хөдөлмөрийн дундаж цалин 0.8 ам.доллартай тэнцэж байгааг зарлаад, дэлхий дахинд буй хамгийн бага ажлын хөлс Хятадад одоо ч оршин тогтносоор буйг тунхагласан.

БНХАУ-ын Ардын их хурлаар “2014 оны зорилтот өсөлтийг 7.5 хувь” гэж тогтоосон. Гэвч энэ оны хувьд өсөлт нь дунджаар 7.2 хувь хүртэл буурахаар байна. Үүнийг Хятадын удирдлагууд “муу үзүүлэлт” гэж харахгүй байгаа.

Хамгийн олон цаг ажиллаж, хамгийн бага цалин авдаг Хятад ажилчид төрийн зардлаас үүдэлтэй инфляцийн өсөлтөд дарлуулах болсныг Лан профессор нуусангүй. БНХАУ-ын Ардын их хурлаар “2014 оны зорилтот өсөлтийг 7.5 хувь” гэж тогтоосон. Гэвч энэ оны хувьд өсөлт нь дунджаар 7.2 хувь хүртэл буурахаар байна. Үүнийг Хятадын удирдлагууд “Муу үзүүлэлт” гэж харахгүй байгаа. Харин “Бодит өсөлт” хэмээн таатай хүлээн авахаар сэтгэлзүйгээ бэлдэж байна.

Өмнөд хөршийн аж үйлдвэрлэлийн бодлого сүүлийн хэдэн жил нэг тийш хэт хазайсан байдаг. Тэд гүүр барьж, зам тавих, хот босгоход ихээхэн хөрөнгө зарцуулж байгаа болохоор ДНБ нь жил бүр 10 хувиар хурдтай өссөн гэх. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэл эрчимжсэн аж. ДНБ-ийг ингэж “өөд нь татаж” байгаа хүчин зүйл бол барилгын төмөр арматур бетоны хэрэглээ болон хувирч байна. Төмөр арматур болон бетоны хэрэглээ 2008 онд 57 хувь байснаа 2009 онд 67 хувь болж өсчээ. Эндээс уншигч та нэг зүйлийг ▶

▶ ажигласан байх. Долоон жилийн дараа АНУ-ыг эдийн засгийн хэмжээгээрээ гүйцэх Хятадын эдийн засгийн өсөлтийн “хөшүүрэг” нь бүтээн байгуулалт байсныг дээрх тоон үзүүлэлт гэрчлэх аж.

ДНБ-ий өсөлтөөрөө дэлхийд тэргүүлдэг Зүүн Ази, Номхон далайн бүс Хятадын эдийн засгийн өсөлтөөс ихээхэн хамааралтай. Өнгөрсөн онд 7.2 хувиар тэлсэн тус бүсийн эдийн засгийн өсөлт ялимгүй суларч, 2014 онд 6.9 хувиар тэлэх төлөвтэй байгааг тус бүсийн Дэлхийн банкны ахлах эдийн засагч Судхир Шетти Сингапураас мэдэгдсэн. Энэ нь ирэх онд 20 сая тонн нүүрс Хятадад нийлүүлэхээр зорьж буй манай улсын хувьд гунигтай мэдээ. Өмнөд хөршийн эдийн засаг бага зэрэг агшиж буйтай холбоотойгоор манай эдийн засгийн өсөлт ч дагаад хумигдах нь.

Дэлхийн банкны тооцоолж буйгаар Хятадын эдийн засаг 7.4 хувиар тэлэх бол манайх 6.3 хувиар өсөх зураглал бий. Өөрөөр хэлбэл, АНУ-ыг “жийхээр” мэрийж буй эдийн засаг Монголынхоос даруй 860 дахин том. Гурван их наяд ам.долларын гадаад валютын нөөцтэй, сүүлийн 30 жилд эдийн засаг нь дунджаар 9.9 хувиар тасралтгүй өссөн “Эдийн засгийн их гүрэн”-ийг дэлхий нийт ажиг байна. Ирэх онд БНХАУ-ын эдийн засаг Дэлхийн банкны таамгаар явбал үл мэдэг өсөлт нь бууна.

Зарим судалгаагаар Хятадын ДНБ-ий өсөлт найман хувиас буувал нийгэм, эдийн засгийн гүн хямралд орно гэж үздэг. Эдийн засаг, үйлдвэрлэлийн өсөлт тус орны олон сая иргэнийг ажлын байртай, хоол ундтай, орон байртай, ирээдүйдээ итгэлтэй байлгаж байна. Энэ өсөлт саарвал ард түмнийх нь итгэл алдарч, улс төрийн удирдлага, дэглэмээ өөрчлөхөд ч хүргэх осолтой болохыг Стратеги судалгааны хүрээлэнгийн Хятад судлалын багийн судлаач Б.Ариунзул ярьж байсан.

БНХАУ-ын дарга Си Зиньпин эдийн засгийн өсөлтийг чухалчилдаг Шанхайн бүлэглэлийн хүн гэгддэг. Түүнийг Зөжиан мужийн дарга байхдаа орон нутгийн эдийн засгийн өсөлтийг 14 хувьд хүртэл хурдасгаж байсан туршлагатай хятадууд одоо ч онцолдог. Түүний хэрэгжүүлж буй бодлогоос харахад Хятадын нийгэмд бугшсан төдийгүй тулгамдсан асуудлыг зоригтойгоор авч шийдэх нь гэж ойлгож болохоор. Өөрөөр хэлбэл, 30 жилийн ДНБ-ий өсөлт энгийн иргэдийн амьдралд ямар бодитой өөрчлөлт авчирсан эсэхийг тэрбээр өнөөдөр шүүн тунгааж байна. БНХАУ-ын хүн амын гуравны хоёр орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой тариачид байдаг. Тиймээс хэрэглээгээ нэмэгдүүлэх чадваргүй гэж үзэх аж. Өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ дөнгөж 35 хувийг дотооддоо хэрэглэдэг тус улс ирэх 10 жилд дээрх тоог ядаж 50 хувьд хүргэх зорилт тавиад байгаа. Хятад бол Азийн найдвар.




Ерөнхий сайд асан, МҮАН-ын дарга Мэндсайханы Энхсайхан

## ИЛТГЭЛ

# ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ПРАГМАТИК НАЦИОНАЛИЗМ

## Яагаад гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж?

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөрийн оронд оруулах гэж улс орнууд хэрэндээ хичээдэг. Энэ ажлыг амжилттай хийж буй орны тоонд яалт ч үгүй АНУ, Хятад хоёр орно. Өнөөдөр дэлхий дээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэрийн дор триллион гаруй ам.доллар эргэлдэж байна. Үүний 50 орчим хувийг хөгжингүй орнууд өөртөө татаж авдаг аж. Хэн хөрөнгө оруулагчдыг татаж чадна, тэд илүү хөгжилтэй байгаа нь нууц биш юм. Урд хөрш Хятадын эдийн засгийн хөгжлийн загварт Гадаадын шууд хөрөнгө оруулалт том байр суурь эзэлдэг. Гадаадын шууд хөрөнгө оруулалт аливаа эрсдлийг хөрөнгө оруулагчид ▶



Эх сурвалж: UNCTAD

► үүрүүлдэгээрээ, тухайн оронд өр үүсгэдэггүйгээрээ зээл, бонд бусад санхүүгийн аргуудаас хамаагүй дээр.

## Гадаадын хөрөнгө оруулалт ба Монгол

Монголын эдийн засагт сүүлийн үед гарсан хамгийн том сөрөг үйл явдал бол гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан явдал билээ. Нуршаад яхав. Зураг харуулья.



## Гадаад болон дотоод хөрөнгө оруулалт


Гадаадын хөрөнгө оруулалт, дотоод хөрөнгө оруулалтын хоорондын уялдаа холбоог зөв ойлгох явдал их чухал.

Нэгдүгээрт, хэмжээ дамжааны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг, дотоодын хөрөнгө оруулалттай харьцуулахын аргагүй. Тэнгэр, газар. Нэн ялангуяа дөнгөж өсч өндийж байгаа Монгол шиг оронд энэ шууд хамаарна.

Хоёрдугаарт, Гадаадын хөрөнгө оруулалт өсөх, буурах хэмжээгээр дотоодын хөрөнгө оруулалт мөн адил өсч, буурна. Гадаадын хөрөнгө оруулагчдаас авсан татвар дотоод хөрөнгө оруулалтын бололцоог бий болгодог. Гадаадын хөрөнгө оруулалт буурч байгаа бол дотоодын хөрөнгө оруулалт буурах нь гарцаагүй. 2015 оны төсвийн төслийг зэрвэс харвал төсвийн хөрөнгө оруулалт зогсохоор байгаа. Улстөрчид яаж ч хоорондоо маргалдаад, хэрэлдээд мөнгө ургаж бий болохгүй. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахаас нааш ирээдүй гэрэлтэхгүй. 2013, 2014 онд Чингис бонд тус болсон боловч эргээд ашиг өгөх төсөл нь хэд билээ, хэзээ билээ гээд бөөн асуудал дагуулна.

## Улс төрийн үзэл суртал

Монголын улс төрчид ертөнцөөс өөрөөр сэтгэдэг гойд улс төрчид биш билээ. Зөв, буруу ярьж байгаа бүхий л үзэл бодол туйлшрал, прагматик национализм, чөлөөт зах зээл гэсэн сэтгэлгээний гурван хэмжигдэхүүний аль нэгт хамаарна.



Хэн яаж ярьж байгаагаас тэднийг танихад тус болох үүднээс улс төрийн үзэл суртлуудыг товч тайлбарлая.

**Туйлшрал.** Хоёр төрөлд хувааж болох биз ээ. Нэгдүгээрт, Гадаадын хөрөнгө оруулалт бол ямар ч ашиггүй, мөлжлөгийн хэрэгсэл гэх тайлбар. Марксист үзэл хэмээнэ. Тооцоо судалгаагүй ингэж ярьж байгаа бол коммунист уламжлалын сэтгэлгээ гэхээс өөр зам байхгүй. Хоёрдугаарт, Гадаадын шууд хөрөнгө оруулалт дарлах, колончлох хэрэгсэл гэх тайлбар. Үндсэрхэг үзэл хэмээнэ. Голдуу популизм үнэртүүлдэг. Популизмд тооцоо судалгаа хэрэггүй байдаг.

**Чөлөөт зах зээл.** Чаддаг чаддаг юмаа хийж худалдаа наймаа хөгжүүлэе гэх тайлбар. Чөлөөт зах зээлийн үзэл хэмээнэ. Олон орон энэ баримтлалыг таашаадаггүй.

**Прагматик национализм.** Хөрөнгө оруулалт ашигтай ч бас зардалтай. Гадаадын хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулахыг дэмжиж байгаа тухайн орон аль аль нь сайн, муу үр ашигаа тооцож хамтарч ажиллая гэх тайлбар. Прагматик национализм хэмээнэ. Нэр томъёо нь Монголд шинэдэж мэднэ. Энэ бол үндсэрхэг үзэл биш шүү гэсэн тодотголыг дахин хэлэх нь зүйтэй байх.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба улс төрийн үзэл суртал

Туйлшрал

Прагматик  
национализм

Чөлөөт зах зээл

## Дүгнэлтийн оронд

Улс төрчид, төрийн дээд албан тушаалтнууд эдийн засгийн амин чухал энэ асуудлаар өөрсдөө зөв ойлголттой байж, ерөөлийг итгүүлж чадах эсэхээс Монгол орны цаашдын хөгжил хамаарна.

Бодлогогүй үг, болчимгүй үйл явдал соёлын зөрүүтэй хүмүүсийн хооронд зөвхөн “айдас” бий болгох бөгөөд “Итгэлцэл”-ийг бүрэн алдуулдаг. Монголын өнөөгийн дүр зураг энэ аж. ■

АСУУДАЛ

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН СААД



ТЕРЭНС ЭДВАРДС

## Хэн ч, хэзээ ч очихгүй байгаа тэр газар бол очиж үзэх ёстой газруудын нэг

Монгол Улсын иргэд эх нутгаа хаана ч байхгүй үзэсгэлэнт байгалийн тогтоцтой гэж харж, боддог. Монгол бол баялаг түүхтэй орон. Засгийн газар эдийн засгийн бодлогынхоо хүрээнд тус салбарт тун бага мөнгө, хүч зарцуулдаг нь харамсалтай.

Тогтвортой аялал жуулчлал нь тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, зарцуулалтыг дэмжиж байдаг. Энэ нь тухайлбал, Монголын нүүдлийн уламжлал гэх мэт устан үгүй болж буй гайхам соёлыг хадгалан үлдэхэд тусалдаг эдийн засгийн идэвхжүүлэгч юм. Уул уурхайн салбар л гэхэд эсрэгээрээ хүн амын тун цөөн хэсэгт л өгөөжөө өгч байх жишээтэй. Байгалийн баялагт хэт их найдан дулдуйдах нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг чангалж, бусад салбарын өрсөлдөх чадварыг унагаж байдаг. Үүнийг товчхондоо Голланд өвчин гэж дэлхий даяар нэрлэдэг.

Ерөнхийд нь харахад аялал жуулчлалын салбар 2014 онд чирэгдсэн өнгө аястай байна. Засгийн газраас гаргасан мэдээллээс үзэхэд 2014 оны эхний долоон сард жуулчлалын визээр орж ирсэн аялагчдын тоо өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 8.5 дахин бага байж. Тэгэхээр энэ жил нийт 210.587 гаднын иргэн Монголд зочилсон гэсэн үг.

Гэсэн ч олон хүн Монголд хөдөлмөр эрхлэх болон бусад шалтгаанаар ирдэг учир дээрх тоо дангаараа итгэж болох бодит тоо болж чадахгүй. “Женко тур Бюро” хувьцаат компанийн санхүүгийн тайлангаас үзэхэд тус компанийн орлого энэ жилийн эхний хагаст 22 хувиар буурсан байна. Соёл, спорт аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл үүнийг баталж, сүүлийн жилүүдтэй харьцуулахад аялал жуулчлал энэ жил нэлээд уналттай байгааг хүлээн зөвшөөрсөн. Харин долдугаар сар салбарын хувьд нэлээд амжилттай байжээ. Гэвч энэ хандлага нь зөвхөн долдугаар сарын дүр зураг аж. Зургаадугаар сарын хувьд тийм ч өгөөжтэй байгаагүй бол наймдугаар сард ч мөн сайнгүй байжээ.

## Өөрөө өөртөө дайсан

Монголын аялал жуулчлалын үйлчилгээ ихэнх жуулчдад дутмаг сэтгэгдэл үлдээдэг. Засмал замуудын хувьд дутагдалтай байдаг нь аяллыг хэт удаашруулж, шөнө үзэгдэх орчин хязгаарлагдмал учир айдас түгшүүрийг дагуулах нь бий. Хэдийгээр Засгийн газар ирэх жил гэхэд хот, аймгуудыг засмал замаар холбохоор төлөвлөж буй ч аймгуудыг дайрсан аяллын маршрутад төдийлэн том нөлөө үзүүлэхгүй.

Засмал замын чанарын хувьд тун тааруу бөгөөд овгор товгор, нүх ихтэй. “Засгийн газар замуудад үнэхээр их ажил хийх хэрэгтэй байна” хэмээн “Нью жуулчин” компанид дөрвөн жил хөтөч хийсэн, одоогоор борлуулалтын менежер хийж байгаа У.Цэцэнбилэг хэлж байв.

Агаарын аялал тун найдваргүй байгааг тэрбээр мөн учирлалаа. Олон долоо хоногийн өмнө нислэгийн компанид захиалга өгч, суудал захиалсан ч нислэгийг байнга хуваарьт өдрөө цуцлагддагийг хэлэх жишээтэй.

Ц.Оюунгэрэл сайд болон борлуулалтын менежер У.Цэцэнбилэг хоёул аялал жуулчлалын компаниуд маркетинг сурталчилгаагаар дамжуулан чадамж өндөртэй жуулчдыг илүү татах хэрэгтэй гэж үзэж байна. Тийм учраас Аялал жуулчлалын яам салбарын төсвийн дийлэнх хувийг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, худалдаа болох “ITB”-тэй хамтрахад зориулж байгаа бөгөөд энэ нь дэлхий даяар аялал жуулчлалын компаниудтай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллахад чиглэж буй.

Гэвч албан газруудын хаяг, тэмдэглэгээг англи хэл дээр байлгахыг хориглохыг оролдсон Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь тус салбарыг хохироож байна. Иргэдийн зүгээс дээрх харийн хэл дээрх хаяг, тэмдэглэгээ нь нийслэлийг гаднын улс шиг харагдуулж байна хэмээн шүүмжилдэг. Харин Оюунгэрэл сайдын хувьд англи хэл дээрх хаягууд жуулчдад ихээхэн тус болдог учир энэ тал дээр эсрэг байр суурийг хүчтэй илэрхийлсэн гэв.

Монголын аялал жуулчлалыг урагш хүчтэй чирдэг үйл ажиллагаануудын нэг “Монгол Ралли” авто аялал байсан ч хүмүүсийн сөрөг хандлагаас үүдэн Монголд ирэхээ бараг болжээ. Арга хэмжээг зохион байгуулагч “The Adventurist” тус ➤



жолоодлогын марафоныг 10 жилийн өмнөөс зохион байгуулж байгаа бөгөөд менежерийнх нь хэлж байгаагаар тэд үргэлж барианы цэгээ шинэ газар, оронд байлгадаг байна. Ирэх онд автомашин сонирхогч зоригтнууд Их Британиас эхлэн Европ, ЕвроАзиар хөндлөн давхиж, Монгол туургатнуудын нэг, Оросын БНБУ-ын нийслэл Улаан-Үүдэд бариандаа орж ирэхээр болоод буй.

Тус арга хэмжээний хүрээнд Монголд үлдээсэн уралдааны машинуудыг зарж, хандивлахын оронд энэ жил анх удаа Монголоос буцаан татаж, Европ руу аваачна. Энэ нь “Нэг ч машин ардаа үлдээхгүй” гэсэн шинэ бодлого аж. Зохион байгуулагч Кэти Вэллингс “Бид хэзээ ч дахин Монгол руу машин импортлохгүй” гэсэн юм.

Дотоодын хэвлэлүүд “Монгол Ралли” уралдааныг олон нийтийн тухыг алдагдуулсан, хөгжиж буй оронд муу машинуудаа хаяад явах гэсэн гаднын залуу жуулчдын ядруу оролдлого хэмээн буруутгасан өнгө аястайгаар харуулж байсан. Гэтэл нөгөө талаас тус арга хэмжээний зохион байгуулагч Виллингс “Дээрх машинуудыг сэргээн засварлаж, асуудалгүй болгодог. Түүнчлэн бид зарах болон хандивлахаас өмнө техникийн үзлэгээр оруулдаг” гэсэн юм. Борлуулалтаас олсон орлого “The Adventurist” компанийн дээрх арга хэмжээнд гаргасан зардлаас хэтэрбэл халамжийн газарт хандивладаг гэж тэрбээр хэлсэн.

Монголын Засгийн газартай үүссэн энэхүү төвөгтэй харилцаа нь тус арга хэмжээг зохион байгуулах нь ач холбогдол гэхээсээ илүүтэй асуудал болж хувирсныг зохион байгуулагч хэлж байгаа юм. Тиймээс оролцогчид заавал Монголд уралдаанаа дуусгах гэж энэ улсаар дамжих шаардлагагүй гэж бид үзсэн гэж тэрбээр онцолсон. Монголчуудын хувьд тус арга хэмжээнээс орж ирдэг байсан олон зууны машины гаалийн татвар, нэмүү өртгийн татвар, онцгой албан татвар, борлуулалтын татвар үгүй болсон гэсэн үг. Хамгийн муугаар бодоход уралдаанд оролцогсдын Монголд аялах хугацаандаа зарцуулах байсан доллар одооноос эхлээд байхгүй болсон.

## Казинод шоогоо хаях уу

Аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл гаднынхныг татах шинэ сонирхлуудыг бий болгох үүднээс мөрийтэй тоглоомыг

хуульчлахаар зорьж байна. Тэрбээр мөрийтэй морин уралдааныг зөвшөөрдөг болгох хуулийг УИХ дэмжинэ гэж найдаж байгаа гэлээ. Үүний зэрэгцээ казиногийн үйл ажиллагааг Монголд зөвшөөрөх ахин нэг хуулийн төслийг өргөн барихаар бэлдэж байгаа аж.

“Мөрийтэй тоглоомыг хариуцлагатай талаас нь хуульчилж чадвал Монголын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө болно. Мөн энэ нь одоогийн эдийн засаг суурилж буй уул уурхайн салбараас ч том эдийн засгийн тулгуур салбарыг бий болгож чадна” хэмээн үл хөдлөх хөрөнгийн “Mongolia Growth Group” компанийн орлогч дарга Харрис Куппермэн хэлж байна.

Тэрбээр мөн мөрийтэй тоглоомыг хуульчилбал Монголын аялал жуулчлал Макаогийн өнгөрсөн арван жил дэх өсөлтийн шууд тусгал болно. Ганцхан Хятадыг аваад үзэхэд тэрбум үйлчлүүлэгч хажууд байна гэсэн юм.

Үйлчлүүлэгчдээ “Төөр, асуудалд ор” хэмээн уриалдаг “The Adventurist” компани ч Монголыг харахан орхиод гарчихаагүй. Тэд тэртээх 13-р зууны үеийн Их Монгол улсын өртөө улаа ашиглан “хэл” залгуулж байсан түүхийг дуурайсан 1000 км үргэлжлэх морин уралдаанаа цаашид ч зохион байгуулсаар байх болно. Тус арга хэмжээний хүрээнд морьдоо түрээслэх малчин иргэдийг авч ажилуулдаг. Монголын морьтон соёлоос улбаалан тус арга хэмжээг монголчууд ч өөрсдөө ихээхэн сонирхдог.

Гэвч салбарын гол сорилт нь эхний ээлжинд Ц.Оюунгэрэл сайд болон аяллын компаниуд Монгол бол давтагдашгүй онцгой газар гэсэн “товойсон” тод өнгийг арилгачихгүйхэн шиг салбараа өөд нь татах явдал юм.

“Монголд юмс тодорхойгүй байдаг нь гаднын зочдын хувьд сэтгэл гонсойх, эмээн түгших гол шалтгаан болдог ч үүнийг нөгөө талаас нь харвал сайн тал бас бий” хэмээн Ц.Оюунгэрэл сайд учирлалаа.

Тэрбээр Монгол руу аялахаар зэхэж буй айлчин гийчид энэ орноос яв цав тодорхой байдлыг хүлээгээд хэрэггүй. Харин өдөр тутам тогтсон хуваариар амьдардаг хүмүүс энэхүү нэгэн хэвийн хэмнэлээ орхиод Монголд ирж үзэх хэрэгтэй гэж зөвлөж байна. ■



## ЗАХИРЛУУД

# МАНЛАЙЛАГЧИЙН ДҮР ТӨРХ

Орчуулсан Б.ЭНХЦЭЦЭГ

Манлайлагчийн суудалд залрахад гаднах дүр төрх гаргасан амжилт, бүтээмжтэй адил чухал үүрэг гүйцэтгэдэг.

Гориллийн /хүн төст сармагчны/ ертөнцөд саарал нуруут эрэгчингүүдийн гарт хүч чадал төвлөрдөг. Эдгээр сүрдэм сүрлэг амьтдын нурууных нь саарал үснээс гадна байр суурийг нь илэрхийлэх онцлох шинжүүд олон бий. Тэд сүргийнхээ бусад гишүүнээс хамаагүй нүсэр биетэй, хоолойных нь өнгө өтгөвтөр бөгөөд дуу нь өндөр байдаг төдийгүй цээжээ хүчтэйгээр дэлдэж сүр хүчээ илэрхийлж, эрх мэдлээ бусдад ойлгуулдаг. Энэхүү зураглал компаниудын ертөнцөд тийм ч хол

зөрүүтэй биш. Компаниудын захирлууд нийтлэг нь зургаан тохой /182 см-тэй тэнцүү хэмжээнээс/ өндөр нуруутай, чийрэг сайхан биетэй, бүдүүвтэр дуутай. Мөн тэдний соролсон мэт урд талын хэсэг буурал үс нь насандаа тохирсон засалттай гялалзсан үсэнд нь уусаж, яв цав зохицсон байдаг. Боссууд өргөн том ширээнийхээ ард шигдэх бус дүүртэл нь өөрийгөө “тараан” эзэлж ажилладаг. Мөн тэд харьяа албатуудтайгаа ярилцахдаа зогсоо байдлаас буюу өндрөөс харж ярих нь элбэг. Тэд харилцан яриан дундуураа нэр төр, сүрийг үзүүлсэн түр амсхийсэн нийтлэг зогсолтууд болон тунхагласан өнгө аястай мэдэгдэл, байр суурийг илэрхийлж байдаг байна.

Горилль ба хүн хоорондын хамгийн

том ялгаа нь хүний нийгэм хурдацтай өөрчлөгддөгт оршдог. Тухайлбал, эмэгтэй болон эрэгтэй хүн, барууны орнууд ба хөгжингүй орнууд, номын болоод номын бус хүний хоорондох эрх мэдэл, хүч чадлын хуваарилалт нэлээд өөрчлөгдөж. Өнөөдөр эмэгтэйчүүд Америкийн олон том фирмийг авч явж байгаа. Жишээлбэл, “Женерал Моторс”-ын Мэри Барра, “Ай Би Эм”-ийн Виржинья Рометтиг нэрлэж болох юм. Дэлхийн 2500 томоохон компанийн 50 гаруй хувийнх нь толгой оффис барууны ертөнцөөс гадна байрладаг. Мөн зожиг атлаа сод ухаантнууд ч өнөөдөр дэлхийн хамгийн эрчтэй урагшилж буй компаниудын хувь заяаг төлөвлөөд сууж буй. “Силикон Валлей” компанийн тэргүүлэх хөрөнгө оруулагчдын нэг Петр Тиел анх “Blanket rule” буюу Хөнжлийн дүрмийг танилцуулсан: Энэ нь хослол өмсдөг захиралд хэзээ ч бүү хөрөнгө оруул гэсэн утгатай.

Захирлуудын хувьд төрөлжилтийн энэхүү эринд хэдэн босс уг хэвшмэл ойлголттой нийцэж ажилладаг вэ. Нэгдүгээрт, тэд өндөр. Малколм Гладвилл “Blink” хэмээх судалгааны номондоо “Fortune” сэтгүүлийн жагсаалтад багтсан 500 компанийн захирлуудын 30 хувь нь 6.2 тохой буюу 188 см болон түүнээс дээш өндөртэй байгааг олж мэдсэнээ бичсэн нь бий.

Зөв ярьж байгаа мэт сонсогддог, харагддаг хүмүүс дээд албан тушаалын төлөөх өрсөлдөөнд үргэлж илүү байдаг байна. Техасын “Quantified Communications” компани 120 удирдах албан тушаалтны тавьсан илтгэлийг энгийн хүмүүст үзүүлж үнэлгээ өгөхийг хүсчээ. Тэдний судалгааны үр дүнд, сонсогчдын үнэлгээний 23 хувь нь дуу хоолойны чанараас шалтгаалж байсан бол илтгэлийн агуулга ердөө 11 хувийг эзэлж байгааг тогтоожээ. Мөн Сан Диего, Дүкийн Их сургууль болон Калифорнийн Их сургуулийн эрдэмтэд хамтран буй 792 эрэгтэй ерөнхий захирлын хөрөнгө оруулагчдад тавьж илтгэлийг сонсжээ. Ийнхүү бусдаас илүү бүдүүн, баргил хоолойтой захирлуудын жилийн дундаж орлого дунджаас даруй 187 мянган ам.доллараар илүү байгааг харуулжээ.

Мөн бие физиологийн хувьд эрүүл чийрэг байх нь захирлуудын ▶

▶ амжилтад ихээхэн хамааралтай байдаг бололтой. Өнгөрсөн есдүгээр сард хэвлэгдсэн Германы Колони Их сургуулийн дэргэдэх хүрээлэнгийн судалгаанд дурдсанаас үзэхэд Америкийн S&P 1500 индекст багтсан компаниудын захирлуудын холын гүйлтэд оролцсон байдлыг үзэхэд дунджаас таван хувиар илүү үнэлэмжтэй байдаг байна.

Зөв сайхан биетэй байх нь хүмүүст удирдагч шиг аашлах итгэл үнэмшлийг бий болгож байдаг бөгөөд бусад хүнд мөн тэр мэт харагдах хүсэл төрүүлдэг байна. Харвардын Бизнесийн сургуулийн Эми Каддигийн хэлж байгаагаар хоёр хөлийн хооронд зай авч газар бат гишгэж, цээжээ урагш түрэн, хоёр мөрөө хойш татан зогсох нь тестостерон буюу эрэгтэй хүний бэлгийн дааврын цусанд нийлүүлэгдэх хэмжээг ихэсгэж,

**Горилль ба хүн хоорондын хамгийн том ялгаа нь хүний нийгэм хурдацтай өөрчлөгддөг оршдог. Тухайлбал, эмэгтэй болон эрэгтэй хүн, барууны орнууд ба хөгжингүй орнууд, номын болоод номын бус хүний хоорондох эрх мэдэл, хүч чадлын хуваарилалт нэлээд өөрчлөгдөж.**

кортизон буюу стресстэй холбогддог стероидын хэмжээг бууруулдаг байна. /Харамсалтай нь энэхүү үйл явц эрсдэлтэй тохиролцоо хийх боломжийг ч мөн ихэсгэдэг байна/.

Ачаалал даах физиологийн чадамж нь удирдагч болоход нөлөөлдөг гэх энэхүү эерэг үзүүлэлтийн хажуугаар зарим сөрөг хэвшмэл ойлголт удирдлага сонгоход нөлөөлдөг байна. Тухайлбал, илүүдэл жинтэй хүмүүс, тэр дундаа эмэгтэйчүүдийг өөрсдийгөө удирдан авч явах чадваргүй хэмээн шүүмжид хүргэдэг. Мөн "Uptalk" буюу өөрийн хэлж ярьж буйгаа асуулт асууж байгаа мэт өндөр өнгөөр төгсгөх зуршил нь өөртөө итгэлгүй, шийдэмгий бус, гүйцэт боловсроогүй түүхий байгааг нь мэдэгдүүлдэг гэж үзэх

боссууд байдаг.

Хүч түрэн гарч ирж, хөгжиж буй томоохон улсуудын компаниудын сэргэн мандалт эрчтэй байгаа ч бидний энэ нийтлэлд хөндөж буй хэвшмэл ойлголтуудыг төдийлэн эвдсэн өөрчлөлт шинэлчлэл гараагүй байна. Тэдгээр улсын ихэнх фирмийн боссууд барууны компаниудын хэв маягийг дуурайхыг хэт оролдож өөрсдийгөө зовоодог. Тэд барууны хослол өмсч, барууны удирдлагын хэв маягаар ярьж, мөн барууны өнгө аясаар харагдаж, ярихыг сургадаг. Түүнчлэн Харвардад хүртэл хүүхдүүдээ хүчээр сургаж байна.

Өндөр технологийн компаниуд үйл ажиллагаагаа тэлж, тодорхой хэмжээнд хүрч сайхан хослол өмссөн захирлыг урин ажиллуулах тэр үеэс ноён Тиелийн "Blanket rule" хэмээх дүрэм мартагддаг. Эмэгтэй манлайлагчдын хувьд энэ тал дээр нэлээд олон янзаар биеэ авч явах бөгөөд үүнийгээ өөр, өөр өнцгөөс харж, тайлбарладаг. Зарим нь чанартай хослол өмсч, урт цагаар ажиллах нь өөрсдийнх нь байр суурь, эрх мэдлийг тодорхойлон харуулж байна гэж үзэх нь бий. Харин бусад нь хүүхдүүдийнхээ сайн ээж, эзэгтэй байгаагаа тодотгон харуулдаг. Тухайлбал, Фейсбүүк компанийн гүйцэтгэх захирал Шэрил Сэндбэрг "Өнгийгөөд хар" хэмээх номондоо гэрийн эзэгтэй, ээжүүд хэрхэн жаргалтай гэр бүлийн амьдрал, ажлын амжилт хоёрыг хослуулах тэрхүү тэнцвэрт байдлын тухай бичсэн байдаг.

## Эрх мэдлийн төлөөх өнгө төрх бүрдүүлэлт

Тэгвэл тодорхой төрлийн хүмүүсийг өндөр албан тушаалд сонгох энэхүү хандлагыг ямар нэг байдлаар өөрчилж, түүнд нөлөөлж болох уу. Зарчмын хувьд удирдах албан тушаалтан шинээр сонгох гэж буй эрх мэдэлтнүүд дээр дурьдсан хэвшмэл ойлголтуудыг түр орхиод нэр дэвшигчдийг гавьяа зүтгэл, давуу талуудад нь үндэслэн цэвэр шүүлт хийн сонгодог гэж боддог. Гэсэн ч нэр дэвшигчийн ажлын намтар түүх зэрэг зохих шаардлагуудын хувьд бүх зүйл хэчнээн төгс байлаа ч сонгон

шалгаруулалтын баг эсвэл хороо үргэлж тэрхүү өөрсдөд нь байдаг үл мэдэх "Х" хүчин зүйлийг тухайн хүмүүсээс хайж, өөрсдийн сэтгэхүйд нийцсэн тэдний төрлийн хүнийг сонгох гэж оролдоно. Үүний нэг шийдэл нь ерөнхий захирал болон захирлуудын зөвлөлд квот тогтоох байдал. Гэвч үүний эрсдэл нь эцэстээ боломжийг тэнцүүлэхээс илүүтэй хэлбэрдэлт болж төгсгөөд байдаг. Тиймээс удирдлагын түвшний мэргэжилтнүүдийн зүгээс бидний тархи толгойноос хэзээ ч хөөгдөхгүй энэхүү хэвшмэл ойлголтууд болон хязгаарласан, ялгаварласан хандлагуудтай эвлэрээд хүлээж ав. Харин дараа нь ид шидийн генетикийн тойргоос гадна төрөгсдөд өөртөө итгэх, эрх мэдэл гээчийг ашиглаж чадахаар мэдрэмжтэй болоход нь туслах хэрэгтэй гэж зөвлөж байна.

Нийгмийн сэтгэлзүйч Эми Кадди 2012 онд "TED" глобал чуулган дээр "Хүч чадлыг илтгэх төрх байдлууд" хэмээх илтгэл тавьсан бөгөөд энэ нь "TED"-ийн интернэтээс татсан хамгийн их ярианы хоёрт бичигдсэн байдаг. Түүний саяхан хэвлэгдсэн "Захирлуудын төрх байдал" номонд, Нью-Йоркийн Ур чадварын инноваци төвийн Силвия Энн Хьюлеттын уриалснаар залуу эмэгтэйчүүдийг Маргарет Тетчер шиг хоолойныхоо өнгийг доошуулж, өндөр өнгөөр ярих, асууж байгаа мэт үгээ төгсгөх, хоолойгоо чичрүүлэх гэх зэргийг тэр чигээр таягдан хаяж, харилцан ярилцаж байгаа үед хүмүүсийн нүд рүү харж байх хэрэгтэй гэнэ. Тэрбээр менежерийн түвшинд ажиллаж буй болон ажиллахыг хүсч буй хүмүүсийг биеийн дасгал сургуулилт тогтмол хийж, аль болох эрүүл чийрэг харагдахыг зөвлөжээ. Энэ нь танд бодит байдлаас хэт тасарсан, хэлбэрдэлт мэт санагдаж болох юм. Гэхдээ өндөр суудал горилогчдыг ерөнхий гадаад төрх, дуу хоолойны өнгө гэх мэт өнгөн талаас нь дүгнэн ялгаварлаад байгааг баримт нотлогоо хүчтэй харуулж байна.

Нэгэн зууны өмнө Ирландын зохиолч, шүлэгч Оскар Вилде "Өнгөц харж, нимгэн боддог хүмүүс л хүнийг зөвхөн гадна талаас нь дүгнэдэггүй" гэж ёжлонгуйгаар хэлсэн байдаг. Харамсалтай нь удирдагчдыг сонгодог удирдлагууд өнөө үед ч ингэж боддог хэвээр бололтой. ■

Эх сурвалж: The Economist

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## ХУРТАЙ ЭХЭЛСЭН АЯЛАЛ

## Э.ЗОРИГТ

Тэнгэр бүрхэж, жихүүн салхи үлээх нь юу юугүй цас орох нь уу гэлтэй. Гэтэл салхи намжиж, бороо дусалж эхэллээ. Аяллын автобус, борооны анхны дусалтай зэрэгцэн хөдөлж, нэгэн цуваагаар хотын замаар хурдлах агаад “Мишээсэн дагина шиг, Миний Улаанбаатар” гэх дуу радиогоор эгшиглэх нь сонсголонтой. Цугласан олон “Магадгүй энэ жилийн сүүлийн бороо байх” хэмээн уйлагнасан тэнгэрийг бэлгэшээж, удахгүй очих газрынхаа тухай энэ тэрийг ярилцах ажээ. 2014.10.10-ны 10:00 цаг. Ийнхүү өнгөрсөн оны онцлох аж ахуй нэгжээр шалгарсан “Шунхлай” групптэй танилцах аялал эхэлнэ.

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас жил бүр “Оны онцлох аж ахуйн нэгж”-ийг шалгаруулдаг уламжлалтай. Шилдгээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагыг баталгаажуулах, тухайн компанийн амжилт туршлагыг бусдад таниулах, цаашид гишүүд хоорондын уялдаа холбоо, хамтран ажиллах хүрээг өргөжүүлэх зорилгоор “Онцлох аж ахуйн нэгжийн аялал” -ыг ийн зохион байгууллаа. Манай сэтгүүлийн хувьд үндэсний баялаг бүтээгчдийн үйл ажиллагааг дэмжиж, сайн туршлагыг нь уншигч захиалагчдадаа хүргэх үүднээс уг аялалд хамрагдсан юм.

## Азид цөөхөн агуулах

МҮХАҮТ-аас хөдөлсөн аяллын цуваа арав гаруйхан минутын дараа АПУ компанийн “АПУ ложистик” төвд ирсэн юм. 12 давхар байшинтай тэнцэх ган төмөр бүхий байгууламж харагдана. Энэ бол АПУ компани ХБНГУ-ын Krones компанитай хамтран дэлхийн

стандартад нийцсэн, хүчин чадлын хувьд Монголдоо хамгийн томд тооцогдох бүрэн хэмжээний автомат агуулах аж. Уг төв нь үйлдвэрээс бэлэн болсон бүтээгдэхүүнийг татан төвлөрүүлж, хадгалах захиалгын дагуу түргэн шуурхай түгээх зориулалттай бүрэн автомат агуулах юм. Уг агуулахын барилга, тоног төхөөрөмж угсралт, программ хангамжийн асуудлыг ердөө 11 сарын дотор шийдсэн гэнэ. Багтаамжийн хувьд Монголдоо хамгийн том буюу 96 мянган шоо метр, арван мянга гаруй поддон /шингэн бүтээгдэхүүнийг багцалсан/ бараа хадгалах хүчин чадалтай аж.

Ложистик төвийн автомат агуулах нь

А, Б гэсэн хоёр үндсэн байгууламжтай. Бүтээгдэхүүнийг А байгууламжид байрлах автомат робот тухайн барааны бар кодийг уншсанаар хүлээн авч автомат дамжлага дээр байрлуулна. Үүний дараа мөн л автомат робот бүтээгдэхүүнийг хадгаламжийн нэгж рүү хүргэнэ. Энэ нь цагт 63 поддон бүтээгдэхүүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд бүрэн автомат үйл ажиллагаатай. Харин Б байгууламж нь цагт 58 поддон бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай түгээлтийн хэсэг юм. Энэ хэсгээс АПУ компанийн бүтээгдэхүүнүүдийг хүссэн тоо, хэмжээ, захиалгын дагуу нэг дороос хурдан хугацаанд зөөвөрлөж ачих боломжтой гэдгийг аяллын хөтөч тайлбарласан. Энэ төв ▶



АПУ компанийн ложистик төв

► жирийн агуулахыг бодвол бүтээгдэхүүн хадгалах, тээвэрлэх зардлыг 3-4 дахин багасгах боломжтой аж. Ингэснээр хэрэглэгчдэд илүү хямдхан үнээр бүтээгдэхүүн авах нөхцөл бүрдэж байгаа гэдгийг үйлдвэрийн ажилчид онцолж байлаа. Шингэн бүтээгдэхүүн хадгалах “ложистик” агуулахын бүх дамжлага бүрэн автомат. Роботод өгөгдөл өгөх ганц нэгхэн ажилчид байх бөгөөд ихэнх ажлыг нь робот хийчихнэ. Үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг хадгалах агуулахын хувьд бол хүний оролцоо бүү хэл, ямар ч гэрэл гэгээгүй. Тусгай кодчлолын бүтээгдэхүүнийг зөөгч аварга том гурван робот л зогсоо зайгүй ажиллана. Ийм агуулах Монголд төдийгүй Азид цөөхөн байдаг гэсэн. Тун сонирхолтой санагдах тус агуулахын дотор талд гэрэл зураг авах, гар утсаар ярих хориотой юм билээ. Учир нь тэнд тусгай кодийн дагуу роботууд ажилладаг тул үйл ажиллагаанд нь өөрчлөлт орох магадлалтай аж.

## Төмөр хүлгийн үзэсгэлэн

Бидний аяллын дараагийн хэсэг “Хьюндай Моторс Монгол” болон “Киа Моторс Монгол” компанитай танилцах

байсан юм. Тансаг зэрэглэлийн суудлын машинуудыг тусгай зориулалтын тайзан дээр эгнүүлж, өнгө өнгийн гэрэл тусгасан нь нүд гялбам. Ард нь том оврын ачааны машинуудыг эгнүүлсэн нь сүртэй ажээ.

“Хьюндай Моторс Монгол” ХХК нь 2009 онд “Шунхлай групп”-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай үүсгэн байгуулагдсан. Тэд БНСУ-ын “Хьюндай Моторс” корпорацийн HYUNDAI брэндийн том, дунд оврын ачааны болон тусгай зориулалтын автомашин, автобусны Монгол Улс дахь онцгой эрхт албан ёсны худалдааны төлөөлөгчөөр сонгогдон үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Мөн саяхнаас “Киа Моторс” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж “Киа Моторс Монгол” компанийг албан ёсоор нээсэн байна. “Хьюндай Моторс Монгол”-ын хувьд Уул уурхай, ачаа тээвэр, ачаа хүргэлт, бөөний худалдааны зэрэг салбарт зориулсан ачааны автомашин, автобус, тусгай зориулалтын автомашиныг зах зээлд нийлүүлдэг. Харин “Киа Моторс Монгол” компаниудын хувьд хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох байгальд ээлтэй, шатахуун

хэрэглэдэггүй, Солонгос улсад үйлдвэрлэсэн эко автомашинуудыг оруулж иржээ. Одоогийн байдлаар Монголын нөхцөлд бүрэн цахилгаан болон хагас цахилгаан хоёр автомашиныг туршиж байгаа аж.

## Жардин

“Шунхлай” группын хамтарсан хөрөнгө оруулалтаар барьж буй томоохон бүтээн байгуулалтын нэг нь яах аргагүй “Jardin Residence” хотхон аж. Давхартаа хоёр айлтай, дөрвөн зүгт харсан саруулхан цонхтой 130-380 ам метр хүртэлх талбай бүхий орон сууцны сонголттой орчин үеийн дээд зэрэглэлийн хотхон аж. Зайсан толгойн урд талд, уулын бэлд, эрүүл цэвэр агаарт байрлах уг хотхонд, сагсан бөмбөг, хөлбөмбөгийн талбай болон ууланд аялах явган хүний зам зэргийг бүрэн шийджээ. Тус хотхоны ерөнхий төлөвлөлтийг хийсэн архитектор Лучиано Космотой хотхоны талаар цөөн хором ярилцсан юм.

**- “Жардин” төсөл бусдаас юугаараа ялгаатай вэ?**

“Жардин” нь оршин суугчдын тав тухтай байдлыг хангасан дээд зэрэглэлийн тансаг хотхон юм. Төслийн нэг давуу тал нь барилгын бүх хэсгүүдэд дээд зэргийн чанартай материал ашигласан. Хүмүүс “Чанартай” гэж хэлэхээр гарт баригдаж, нүдэнд үзэгдэх зүйлийг хайдаг. Харин бидний бүтээн байгуулалт шалан доор, хананы цаана гэх мэт далд газартаа ч дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, технологийг ашигласнаараа давуу. Адаглаад Германы “Ter Hurne” брэндийн сайн чанарын байгалийн тосолгоотой цэвэр царс модон шал, хаалгыг сонгосон нь оршин суугчдынхаа тав тух, дуу чимээний тусгаарлалтыг хэрхэн бүрдүүлснийг илтгэх нэг шалгуур болох байх. Францаар “Jardin” гэдэг нь цэцэрлэгт хүрээлэн гэсэн утгыг илэрхийлж байдаг тул бид тав тухаас гадна хүрээлэн буй орчинд илүүтэй анхаарсан.

**-Дотоод засал, интерьерийн хувьд та юуг онцлох вэ? ►►**



АПУ ложистик төвтэй танилцаж байгаа нь

► -“Жардин”-д долоон төрлийн интерьерийн шийдэл, өнгө төрх бүхий 130-380 ам метр талбай бүхий байрнаас та сонголтоо хийж болно. Өөрөөр хэлбэл, бид зөвхөн байр бус интерьерийн цогц шийдэл санал болгож байгаа юм. Зарим ерөөнд Газрын дундад тэнгисийг санагдуулам гүн хөх, номин ногоон өнгөнүүдийг ашигласан байхад зарим ерөөнд цэвэр модон доторлогоотой хана бүхий Азийн сонгодог хэв маягийг харах боломжтой. “Жардин” төсөлд хүний тав тухтай амьдралыг бүрдүүлэхэд анхаарсан нь гал тогоо, хувцасны өрөөг бүрэн тохижуулж бэлтгэснээс харагдана.

#### -“Жардин” оршин суугчиддаа өөр ямар давуу талыг амалж байгаа бол.

-Оршин суугчдын цагийг хэмнэх Жи клуб хаус нь шаардлагатай үйлчилгээг нэг дор цогцлоосны дотор дээд зэрэглэлийн ресторан, тусгай үйлчилгээ ч бий. Тусгай үйлчилгээнд нь таны машиныг угаалгах, үзвэр болон онгоцны билет захиалах гэх мэт үйлчилгээгээр хангахаар төлөвлөгдсөн. Мөн “Жардин”-д оршин суугчдын таалалд нийцэхүйц усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөгийн болон хөлбөмбөгийн талбайтай. Үүнээс гадна “Жардин” хотхон цэцэрлэгжилтэд ихээхэн анхаарч ажилласнаас гадна гэрэлтүүлгийн тал дээр ч дээд зэргээр анхаарсан. Мөн хотхонд дуудлагын үйлчилгээ 24 цаг ажиллах бөгөөд та гэрээ цэвэрлүүлэх, машинаа асаалгах гээд 200 гаруй үйлчилгээг авч болно.

## АПУ+С

АПУ бол шингэн бүтээгдэхүүний салбарт Монголдоо шилдэг нь гэдгийг тус компанийн шинэхэн өлгийдөж авсан сүүний үйлдвэрээр зочлоход дахин батлагдана. Зочдын хувьд зориулалтын нөмрөг, малгай, бээлий өмсөж, тусгай ариутгалын өрөөгөөр дамжиж байж шинэхэн сүүний үйлдвэрт нэвтрэх эрхтэй болдог аж. Босго давахын төдийд хөөрүүлсэн сүүний сайхан үнэр хамар цоргих нь нэн таатай. Бидний зочилсон эхний хэсэг бол сүү хадгалах цэг. Энэ хэсэгт үнээний шинэхэн сүү тусгай зөөвөрлөгч машинаар сүүний



АПУ компанийн “Сайн” брэндийн бүтээгдэхүүн

үйлдвэрт хүргэгдэж ирнэ. АПУ ХК нь Улаанбаатар болон Төв аймагт сүү цуглуулах 12 цэг байршуулж, 340 орчим малчин фермерүүдээс өдөртөө 60-80 тонн сүү хүлээн авдаг байна. Энэ сүүг тусгай зориулалтын хоёр саванд зааврын дагуу хадгална. Эндээс сүү найрлагын хэсэг рүү зөөгдөнө. Сүүгээр тараг, зөөхий, жимстэй сүүний алийг нь хийхийг энэ дамжлага шийддэг аж. Тусгай орц, найрлагын дагуу сүүг боловсруулсаны дараа савлах хэсэгт бэлэн болсон бүтээгдэхүүн маань шилжинэ. Савлагааны хэсгийн автомат роботуудыг харахад зугаатай.

Үйлдвэрт гурван төрлийн савлагч робот байх бөгөөд тус тусдаа өөр өөр бүтээгдэхүүн савлана. Үйлдвэрийн эдгээр шат дамжлага бүрэн автомат бөгөөд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, зөөвөрлөлтийн горимыг нарийн сахидаг аж. АПУ ХК-ийн уг үйлдвэр одоогийн байдлаар “Сайн”, “Маамуу”, “Цэвэр сүү” гэсэн нийт 21 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байна.

Бүтээгдэхүүний савны хувьд “Сайн”, “Маамуу” зэрэг бүтээгдэхүүнийнд Швед улсын “эколин” гэдэг савлагааг ашигладаг аж. Уг савлагаа нь агаар ►

► үл нэвтрүүлэх чанар (Gas barrier), гэрэл үл нэвтрүүлэх чанар (Light barrier), үнэр үл нэвтрүүлэх чанар (Aroma barrier) бүхий дан байгалийн гаралтай түүхий эдээр хийгддэг бөгөөд шингэн хүнсний үйлдвэрлэлд байж болох хамгийн хөнгөн савлагаа гэсэн.

Уг үйлдвэрийг барихын тулд “Шунхлай” группын охин компани болох “АПУ” ХК 46 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Тус үйлдвэр жилд 45 сая литр буюу Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг бүрэн хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай гэдгийг аяллын хөтөч сануулсан.

## Онцлох хөрөнгө оруулалт

Эрүүл мэнд эрхэм баян гэдэг. Тэгвэл монголчуудын эрүүл мэндийг сахин хамгаалахаар үндэсний тэргүүлэх гурван компани болох MCS групп, “Энержи ресурс” ХХК болон “Шунхлай” групп хамтарч нийгмийн хариуцлагын хүрээнд “Интермед” эмнэлгийг байгуулж энэ оны тавдугаар сард үйл ажиллагааг эхлүүлжээ. “Интермед” эмнэлэг нь Хан-Уул дүүргийн 15-р

хорооны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд таван давхар бүхий дөрвөн барилгаас бүрдэх аж. Эмнэлгийн гаднах тохижилтоос аваад дотоод зохион байгуулалт гээд бүгдийг хүний эрүүл аюулгүй байдалд тааруулж хийсэн байна. Адаглаад эмнэлгийн дотор талын хана шатны бариул болон бүх будагч бодис нь нян устгах зориулалттай гэсэн. Мөн халдварт өвчтэй хүмүүсийг үзэх ерөөний агаарын урсгал нь шууд гадагшаа чиглэлтэй бөгөөд эмнэлгийн гэрэлтүүлэг, тасалгаа хоорондын зохион байгуулалт тэрбүү хэл хана, шалны цаад талын халаалтын систем нь хүртэл эмнэлгийн зориулалттай аж. Тийм ч учраас “Интермед” эмнэлэг нь европ стандартын дагуу Монголд баригдсан анхны эмнэлэг болжээ.

Тус эмнэлэг хэвтэн эмчлүүлэх 91 ортой бөгөөд мэс засал, дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн үндсэн тасгуудаас гадна нүд, шүд, чих, хамар, хоолой, мэдрэл, арьс, харшлын нарийн мэргэжлийн кабинетуудтай юм билээ.

Нэг монгол хүн жилийн хугацаанд

гадаадад эмчлүүлж, оношлуулахад дунджаар 20 гаруй сая долларын зардал гардаг аж. Тэгвэл энэ эмнэлэг нээгдсэнээр Монголд хийгддэггүй бүх төрлийн шинжилгээг хийх боломжтой гэдгийг эмчлэгч эмч нар онцолж байлаа. Түүнчлэн Монголд хийдэггүй байсан дөрвөн төрлийн хагалгаа, 10 орчим төрлийн шинжилгээг хийдэг байна.

“Шунхлай” групптэй танилцах аяллын талаар товчхон дурдахад ийм байна. Монголын эдийн засаг сайнгүй байгаа ч тоотой хэдэн үндэсний томоохон компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд гадаад зах зээлээс ам.долларын зээл авч, тэрбум тэрбумаар нь хөрөнгө оруулалт хийсээр. “Шунхлай” группын хийсэн хөрөнгө оруулалт бүр нь олон улсын стандартад нийцсэн Монголдоо төдийгүй Азидаа дээгүүрт орох бүтээн байгуулалт болж чаджээ. Ийм зүйл хийснийхээ төлөө долларын ханшийн өсөлтөд дарамтлуулж санхүүгийн байдал нь дээсэн дөрөөн дээр дэнжигнэхэд хүрч буйг бодлого шийдвэр гаргагчид мэддэг болов уу. ■

## УЛС ТӨР

# НАМУУДЫН УЛС ТӨР, НИЙГЭМ ДЭХ ҮҮРЭГ



**С.ЗУЛЬФИКАР**

Удирдлагын академийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор/

Улс төрийн тогтолцооны салшгүй хийгээд дийлэнх тохиолдолд улс төрийн үйл явцын цөм нь болж байдаг институт (улс төрийн байгууллага)-ууд бий. Үүний нэг нь улс төрийн нам юм. Улс төрийн намын түүхэн хөгжил нь түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үр дүнтэй шууд холбогддог. Нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа институтийг нэг бол өөрчлөгдөх эс бөгөөс нийгмийн харилцаанаас арчигдах хувь тавилан хүлээж байдаг. Улс төрийн нам нь улс төрийн харилцааны салшгүй хэсэг болоод даруй 300 гаруй жил болж

байгаа хэдий ч лав ойрын жилүүдэд улс төрийн тогтолцоо, үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болсоор байх нь. Энэ нь улс төрийн нам нийгэм-улс төрийн харилцаанд тодорхой (зарим тохиолдолд тэргүүлэх) үүрэгтэй байгаатай холбоотой болов уу. Иймд улс төрийн намууд нийгэм-улс төрийн харилцаанд ямар үүрэг хүлээж, хэрэгжүүлж байгааг хэлэлцэх шаардлага тавигдаж байна. Тус өгүүлээр дамжуулан улс төрийн намын үүргийг улс төр судлалын онол, арга зүйн хандлага, ангилалын хүрээнд шинжлэн, тэдгээр үүргийг эрх зүйн харилцаагаар хэрхэн зохицуулж ►

► байгааг хэлэлцэхийг зорилоо.

Нам “party” нь латин гаралтай (pars) үг бөгөөд хуваагдах, салах гэсэн утгатай. Тухайн үед ижил утга бүхий сект “sect” (латины secare - таслах, цавчих, хайчлах, хуваах “to sever, to cut, to divide”) гэсэн үг мөн дээрх утгаар хэрэглэгдэж байжээ. XVI зуунаас улс төрийн эсрэг үзэл санаатай хүчин бий болж, хэлбэрших үед буюу нэг хүний гарт засаглал төвлөрч түүний эсрэг эрх мэдэл бүхий бүлгүүд нэгдэн гарч ирсэнээр тэдгээр бүлгүүдийг тусгайлан нэрлэхийн тулд “party” гэдэг үг улс төрийн хэрэглээнд нэвтэрсэн. Нам судлаач Ж.Сартори улс төрийн намыг “Улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн бүлэг” гэж тодорхойлсон байна.

илэрхийлдэг байна.

Хуульч Б.Чимид улс төрийн намыг дараах байдлаар энгийнээр тодорхойлсон байна. “Аливаа нам нь засаг төрийн эрх мэдлийн төлөө чадвал олонх, ядвал цөөнх, гацвал ганц суудалтай болохын төлөө ажилладаг”. Төр барихад оролцох юм уу, эсвэл түүнд шууд хяналт тавьж нөлөөлөх хувь зохиолтой учраас түүнийг улс төрийн байгууллага гэнэ. Нам бол нийгмийн удирдлагын буюу нийтийн эрх зүйн субъект биш. Эрх зүйн үүднээс бол иргэний нийгмийн нэгээхэн хэсэг, хүн амын тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн байгууллага юм. Дээрх тодорхойлолт улс төрийн нам бол өнөө цагт нийгэм-улс төрийн харилцаанд түлхүүр үүрэгтэй болохыг илэрхийлж байна.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

Үүний зэрэгцээ нам гэсэн ойлголттой ойролцоо утгаар фракц “faction” гэсэн үг хэрэглэгдэж байжээ. Гагцхүү нам “party” болон фракц “faction” гэсэн үг яг ижил утга илэрхийлдэггүй. Фракц нь улс төрийн сэтгэлгээний түүхэнд удаан хэрэглэгдэж ирсэн нэр томьёо бөгөөд латины “facere (to do, to act-хийх, үйлдэх)” гэсэн үгнээс гаралтай юм. Хожим энэ үг латин хэлнээ “factio” хэмээн бичигдэх болж улс төрийн бүлгийн эмх журамгүй байдал, зохион байгуулалтыг сулруулах үйлдэл, нийгмийг хагаралд хүргэх гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Энэ үгний ерөнхий утга нь латин хэлээр бие даасан байх, сэхүүн зан, харгис, хэрцгий гэсэн утгыг

Харин хэд хэчнээн, ямар үүрэг гүйцэтгэж байгаа нь сонирхол татах нь дамжиггүй. Үүрэг гэсэн ойлголтын хүрээнд тухайн субъект эсвэл этгээд дааж авсан, заавал хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаа, ажил төрлийг тодорхойлж илэрхийлсэн байдаг. Тэгвэл нийгэм-улс төрийн амьдралд улс төрийн нам өөрт олгосон эрхийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой буюу дааж авсан, эсхүл тодорхой нөхцөл байдал бүрдсэн үед хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг улс төрийн намын нийгэм-улс төрийн харилцаан дахь үүрэг гэж ойлгож болохоор байна. Улс төрийн нам нь нийгэм - улс төрийн харилцаанд буюу бүхэлдээ

улс орны амьдралд тав эсхүл дөрвөн үндсэн үүрэгтэй болохыг барууны улс төр судлаачид тэмдэглэжээ. Зарим тохиолдолд зургаа, долоон үүргийн талаар ч хэлэлцсэн байна. Нөгөө талаар улс төрийн намын үүргийг тодорхой тоонд хязгаарлах боломжгүй гэж үзэх хэсэг ч бий. Харин улс төрийн намын үүргийг улс төр судлалын тодорхой судлагдахуун болгон авч үзэн нийгмийн бүхий л хүрээнд дэх оролцоо, түүнээс үүдэлтэй үүргийг дараах байдлаар бүлэглэн тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгаа, зохион байгуулалтын хэлбэр болно;
- Төлөөлөх – нийгмийн тодорхой хэсгийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэлийг төлөөлнө;
- Засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх улс төрийн өрсөлдөөнд идэвхтэй оролцогч байна;
- Нийгмийн олон талт ашиг сонирхлыг нэгтгэн, төрийн бодлого болгоно;
- Улс төрийн манлайлагчид, элит хэсгийг сонгох, бэлтгэх, байршуулах зэрэг болно.

Анхны ардчилсан сонгуулийн дараа 1992 оны нэгдүгээр сард Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталж түүнд “Монгол Улсын иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”-г бататгаж намуудаас засаг төрийн сонгууль, үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоосон байдаг. Түүнээс хойш улс төрийн намууд шинээр үүсэх, өөрчлөн байгуулагдах (нийлэх, нэгдэх, тусгаарлах, салах), сонгуульд дангаар болон эвсэн оролцох зэргээр улс төрийн амьдралын мөнхийн хөдөлгөөнд байсаар иржээ. Тухайлбал, 2006 онд Улсын дээд шүүхэд бүтгэлтэй 27 улс төрийн нам байсан бөгөөд Улсын дээд шүүхэд шинэчлэн бүртгүүлээгүй долоон намыг татан буугдсанд тооцсон байна. Одоогийн байдлаар Монгол Улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22 улс төрийн нам байна. 2012 оны 10 сарын 23-ны өдөр 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын дээд шүүх бүртгэжээ. Монголын ►

▶ улс төрийн намууд нийгэм-улс төрийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байгааг дээрх таван ангиллын хүрээнд төсөөлж эсхүл тайлбарлаж болох хэдий ч улс төрийн намуудын эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг, түүнтэй уялдсан харилцааг тулгуур болгон дүн шинжилгээ хийх нь илүү зохимжтой гэж судлаачын зүгээс үзэж байгаа болно.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь ардчилсан төр-улс, үндсэн хуульт бүгд найрамдах улсын зайлшгүй шинж чанар болдог. Улс төрийн намуудыг зохион байгуулалтын бүлэг, үзэл санааны бүлэг, нийгмийн бүлэг гэж үздэг билээ. Нөгөө талаар улс төрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий бүлэг ч гэж үзэх нь бий. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаан дахь олон урьгалч үзлийг тодорхой үзэл санааны хүрээнд нэгтгэх зохион байгуулалт нь улс төрийн намаар дамжин бодит биелэл болж байдаг. Үүний тулд иргэд эвлэлдэн нэгдэж, тодорхой улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалыг суурь болгосон улс төрийн нам байгуулдаг байна. XX зууны 90-ээд оны эхэнд пост-коммунист орнуудад өрнөсөн улс төрийн үйл явцын нэгэн адил Монгол Улсад олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Ийм ч учраас иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургалч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй санал нэгдэж байна.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх зохион байгуулалтын нэг хэлбэр нь улс төрийн нам мөн гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг тунхагласан 12 дугаар бүлгийн 13.10 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намын тухай ойлголтыг тодорхойлохдоо түүний нийгмийн гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах үүргийг тодорхой зааж өгчээ. Улс төрийн намын тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4.1 дэх зүйлд “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг

сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.” гэсэн байна. Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намыг тодорхойлсон байдал нь улс төрийн нам бол тодорхой үзэл бодол, ашиг сонирхлын хүрээнд иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн улс төрийн зохион байгуулалт болохыг бүрэн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх улс төрийн зорилго бүхий зохион байгуулалт гэж ойлгогдож байгаа юм.

Иргэд улс төрийн намын зохион байгуулалтаар эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхдээ ардчилсан төр-улсын үнэт зүйлийг хүндэтгэх, Үндсэн хуулийн зарчмыг баримтлал болгохыг мөн адил хуульчилсан. Энэ нь улс төрийн нам иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангахдаа хувь хүн, төр, нийгмийн ямар үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, ямар үнэт зүйлийг зөрчихгүй байхыг хуульчилсан зохицуулалт болжээ. Үндсэн хуульд “Нам, олон нийтийн бусад бүх байгууллага төр, нийгмийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ” гэсэн бол Улс төрийн намын тухай хуульд “Монгол улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаврлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно” гэж маш тодорхой зааж өгчээ. Монгол Улс ардчилсан дэглэмтэй, хүний эрх, эрх чөлөөг бүхий л талаар дээдлэсэн улс болохын хувьд улс төрийн нам байгуулах замаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хуульчилсан бөгөөд нөгөө талаар улс орны бүрэн эрхт байдал, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа үзэл санаа, зорилго бүхий улс төрийн зохион байгуулалт, эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаа, оролдлогыг хориглосон байна.

Төлөөллийн үүрэг - ардчиллыг өргөжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэд, сонгогчдын төлөөллийг хангах үүргийг улс төрийн тодорхой зохион байгуулалтаар дамжуулан хэрэгжүүлэхийг улс төрийн практик нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн байдаг. Иргэд тодорхой төлөөллийн байгууллага, этгээдээр дамжуулан улс төр, төрийн захиргааны түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад оролцох хэлбэрийг шууд бус ардчилал гэж нэрийдэх нь бий. Иргэд тэдний нэрийн өмнөөс бодлого тодорхойлж, шийдвэр гаргах этгээдийг сонгож, түүгээр дамжуулан өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах, асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой байдаг. Иргэд сонгууль өгсөний дараа хууль тогтоох, шийдвэр гаргах улс төрийн институтын үйл ажиллагаанд шууд оролцох боломжгүй. Орчин үед үндэсний түвшинд улс төрийн үйл явцад иргэдийг татан орлуулж байгаа зохион байгуулалт нь шууд бус буюу төлөөллийн ардчиллын хэлбэр юм. Учир нь үндэсний түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргахад иргэдийг шууд оролцуулах цаг хугацаа, орон зай, зохион байгуулалтын боломж хязгаарлагдмал байдаг нь шууд бус ардчиллыг өргөжүүлсэн. Нөгөө талаар улс төрийн бодлого, шийдвэрийг мэргэшсэн, чадварлаг, тогтвортой хэрэгжүүлэхийн тулд мэргэшсэн улс төрийн институтууд бий болсон байна. Тухайлбал, парламент, Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа нь бодлого тодорхойлж, шийдвэр гаргах улс төрийн мэргэшсэн, тодорхой эрх, чиг үүрэг бүхий институтууд юм.

Төлөөллийн ардчиллын бодит илрэл нь хууль тогтоох, улмаар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх институт, субъектийг сонгох, томилох явдал юм. Монгол Улсад хууль тогтоох байгууллага нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх улс төрийн институт болох бөгөөд түүний гишүүдийг сонгох сонгуулийн үйл ажиллагаанд улс төрийн намууд голлох үүрэгтэй оролцдог. Үүнээс үзвэл улс төрийн нам нь иргэдийн хүсэл сонирхлыг улс төрийн үйл явцад төлөөлөх үүрэг хүлээсэн улс төрийн байгууллага буюу зохион байгуулалт болж байна. ■

Үргэлжлэл бий